



Гүйцэтгэлийн аудитын тайлан

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТУЛД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫГ ОНОВЧТОЙ ТОДОРХОЙЛЖ, БОЛОМЖИТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ НЬ ТӨСВИЙН ХҮНДРЭЛИЙГ БУУРУУЛАХААР БАЙНА.

2022 оны 06
дугаар сар

Аудитын сэдэв: “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ” /2019-2021 ОН/



Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4

Бүлэг 1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогыг үр дүнтэй оновчтой тодорхойлохоор байна.....	6
1.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг шинэчлэхээр байна.....	6
1.2. Компанийн засаглал, үйл ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, үр нөлөөг дүгнэхээр байна.....	7

Бүлэг 2. Хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөн, хянаж, батлуулан, зорилтот түвшнийг хангаж, үр ашигтай ажиллуулах шаардлагатай байна.....	11
2.1. Аймаг, сумын Засаг дарга харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний шалгуурыг батлах, дүгнэх ажил хангалтгүй байна.....	11
2.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орлогын бүрдэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.....	12
2.3. Хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж, үр нөлөөг дүгнэхээр байна.	18
2.4. “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн орлогын 68 хувийг улсын төсвөөс, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн орлогын 78 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна....	19

Бүлэг 3. Хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулан, үр нөлөөг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.....	24
3.1 Төрийн хяналтаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, үр нөлөөгүй байна.....	24
3.2 Дотоод хяналтыг сайжруулж, хөндлөнгийн хяналтаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцох нь зүйтэй байна.....	25
3.3 Хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны талаар олон нийт мэдээлэлгүй байна.....	27
ДҮГНЭЛТ:	28
ЗӨВЛӨМЖ:	28
Холбогдох байгууллагын санал:.....	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АУЭХС	Алтай улиастай эрчим хүчний систем
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТАГ	Төрийн аудитын газар
ТӨ	Төрийн өмч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨК	Төрийн өмчит компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани

ХҮСНЭГТЭН ТОВЬЁГ

№	Хүснэгтийн нэр	Хуудас
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан хуулийн этгээдийн судалгаа	5
Хүснэгт 2	Хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ, дүгнэсэн байдал	10
Хүснэгт 3	Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, тайлагнал /сая.төгрөг/	12
Хүснэгт 4	Орон сууцны зээлийн эргэн төлөлтийн хөрөнгийн эргэцийн чадварын судалгаа	16
Хүснэгт 5	Хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ	18

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийх аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Аудитыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх ➤ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх ➤ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, холбогдох салбарын яам, төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага, агентлаг, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын ямар нэгэн хязгаарлалт байхгүй. Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэлээ. Аудитаар “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т оролцогч хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин, Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилтын хэрэгжилт, хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Хүндрэл бэрхшээл

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Ж.Бүжинханд, Д.Цэрэнханд, аудитор Э.Сүнжидмаа, Г.Энхдэлгэр, Б.Цэвэлмаа, Н.Гэрэлмаа, С.Санчирмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ. Аудитын талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайлан, судалгааг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэсэн.

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь аудитад хамааралтай нотлох баримт бичгийг бүрэн хангалттай ирүүлээгүй, дарга, нягтлан бодогч нь аудитын явцад харилцан холбоогүй байсан нь хүндрэлтэй байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Гүйцэтгэлийн аудитаар ТӨХК 1, ААТҮГ 7, УТҮГ 4, нийт 12 хуулийн этгээдийг хамруулсан. “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ-ыг аймгийн ИТХ-ын 2022 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор татан буулгах шийдвэр гарсан тул УАГ-с ирүүлсэн судалгааны хүрээнд аудитад хамруулж үзлээ.

Хүснэгт-1

Аудитад хамрагдсан хуулийн этгээдийн судалгаа

ДД	Хуулийн этгээдийн			Хариуцлагын хэлбэр	Өмчийн хэлбэр	Үйл ажиллагааны чиглэл
	Нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар			
1	“Говь-Алтай АЗЗА” ХК	2634392	000151919	Хувьцаат компани	100% төрийн өмч	4100-Хайрган болон хатуу хучилттай зам барих, зам талбайн тохижилт
2	“Ундарга-Алтай” ААТҮГ	2625385	514001011	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	4329-Тоног төхөөрөмжийн угсралтын үйл ажиллагаа, 3600-Ус хуримтлуулан ариутгаж түгээх үйл ажиллагаа, 38120-Бохир ус хаягдал цэвэрлэгээ ариутгалын үйлчилгээ
3	“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ	3244849	000216537-	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	38110-Аюулгүй хог хаягдлыг цуглуулах
4	“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ	3253821	513002003	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	Үл хөдлөх хөрөнгийн худалдаа, зуучлал, түрээс, архитектур инженерийн үйл ажиллагаа болон холбогдох техникийн зөвлөх үйлчилгээ
5	“Суурин дулаан” ААТҮГ	8304173	514001019	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	Дулаан хангамж
6	“Солонго дулааны станц” ААТҮГ	8304173	514001019	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	4290-Дулаан хангамж
7	“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ	3244598	514001005	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	Дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх үйл ажиллагаа
8	Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ	3244644	235076	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж
9	“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ	3255468	216547	Улсын төсөвт үйлдвэрлэлийн газар	100% Орон нутгийн өмч	Спортын бусад үйл ажиллагаа
10	“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ	3254933	568001005	Улсын төсөвт үйлдвэрлэлийн газар	100% Орон нутгийн өмч	Инновацийг хэрэглээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашг өрсөлдөх чадвар бүтээмжийг дээшлүүлж нийгмийн үйлчилгээг сайжруулах
11	“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ	2625105	568001004	Улсын төсөвт үйлдвэрлэлийн газар	100% Орон нутгийн өмч	5510-Зочид буудал, амралтын газар, түр хоноглох байрны үйлчилгээ, 8411-Төрийн байгууллагын туслах үйл ажиллагаа, 56109-Зоогийн газар, гуанз цайны газрын үйлчилгээ
12	Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ	3255751	235018	Улсын төсөвт үйлдвэрийн газар	100% Орон нутгийн өмч	02100-Ойн аж ахуй мод бэлтгэл, 35300-Цахилгаан хий уур агааржуулалт, 36000-Ус хуримтлуулах, ариутгах, түгээх ажиллагаа, 43900-Барилгын бусад тусгай ажил, 81100-Барилга байшин болон цэцэрлэг газрын гадарга арчлах, хамгаалах үйл ажиллагаа, 49210-Хотын болон хот орчмын хуурай замын зорчигч тээвэр, 49221-Таксины үйлчилгээ

Эх сурвалж: Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

БҮЛЭГ 1: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй байгаа эсэх

Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогыг оновчтой тодорхойлохоор байна.

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн эсэх

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг шинэчлэхээр байна.

1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.

1.1.1.1 Компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн ойлголт бөгөөд ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо юм.

1.1.1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоот, эсхүл төсөвт төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх шаардлага үүссэн.

1.1.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар. 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг”, 15 дугаар зүйлийн 15.1-т “Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна” гэж заасан.

1.1.1.4. 2021 онд Говь-Алтай аймгийн ИТХ-ын тогтоолоор 3 үйлдвэрийн газар байгуулан дээрх хуулийн заалтын дагуу “Алтай усан спорт, чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ, “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ, “Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ гэж нэрлэсэн. Энэ нь дээрх газруудыг орон нутгийн өмчит бус төрийн өмчит хуулийн этгээд гэх олголтыг олон нийтэд төрүүлэхүйц байна.

1.1.1.5. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ”, 18.3-т “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”, 18.4-т “Орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулна” гэж заасан. Түүнчлэн тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12-т “орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг...” Иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэрэгжүүлэхээр заасан. Харин холбогдох хууль тогтоомжид орон нутгийн өмчит хуулийн

этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн талаар тодорхой тусгаагүй тул ойлгомжгүй, харилцан адилгүй байна.

1.1.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалд үнэлгээ хийж, түвшин тогтоогоогүй байна.

1.1.2.1. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”-ыг баталсан. Компанид засаглалын үнэлгээг хийж, түвшин тогтоохын тулд тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх хамгаалагдсан байдал, ТУЗ-ын үйл ажиллагааны үр өгөөж, гүйцэтгэх удирдлагын менежментийн чадвар, компанийн нээлттэй байдал болон нийгмийн хариуцлага, компанийн оролцогч талуудтай харилцах харилцаа зэргийг үнэлэхээр байна.

1.1.2.2 Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс аудитад хамрагдсан хуулийн этгээдүүдэд засаглалын үнэлгээ хийж, түвшин тогтоогоогүй байна. Энэ нь аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэхтэй холбоотой.

1.1.3 Компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүрэг болон бүрэн эрхийг хэрэгжүүлэгч этгээдийн асуудлыг компанийн дүрэм болон бусад эрхийн актуудад нарийн тусгахаар байна.

1.1.3.1. Төрийн эрх үүргийг түүний захиргааны олон байгууллагууд өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлдэг. Иймээс төрийн эзэмшиж буй хувьцаатай холбоотой эрх, үүргийг тухайн компанид төрийн захиргааны ямар байгууллага, хэрхэн хэрэгжүүлэх талаар түүний дүрэмд тодорхой зааж өгөх нь зүйтэй. Ялангуяа төр 100% хувьцааг эзэмшдэг тохиолдолд тухайн компанийн хувьцаа эзэмшигчийн эрх үүрэг болон бүрэн эрхийг хэрэгжүүлэгч этгээдийн асуудлыг компанийн дүрэм болон бусад эрхийн актуудад маш нарийн тусгасан байвал зохимжтой.

1.2 Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

1.2 Компанийн засаглал, үйл ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, үр нөлөөг дүгнэхээр байна.

1.2.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааг хөгжүүлэх хэтийн бодлогогүй байна.

1.2.1.1. Компанийн засаглалын зорилго нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн бүрэн бүтэн байдлыг хөхүүлэн дэмжихэд шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлэх, ингэснээр эдийн засгийн өсөлт, нийгмийн хариуцлага, шударга, ил тод зах зээлийг дэмжих явдал юм. Компанийн засаглалын зарчмууд нь дараах 6 бүлгээс бүрддэг байна. Үүнд:

- ✓ Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх
- ✓ Хөрөнгө эзэмшигчдийн эрх, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах өмчлөлийн үндсэн чиг үүрэг
- ✓ Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагч
- ✓ Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг
- ✓ Мэдээллийн нээлттэй, ил тод байдал
- ✓ ТУЗ-ийн үүрэг хариуцлага

1.2.1.2. Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолын хавсралтаар “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийн зорилго нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх зарчим, ёс зүй, хэв шинжид тулгуурласан, аж ахуйн үйл ажиллагаа удирдан зохион байгуулах нийтлэг арга барил бүхий үндэсний компани, бизнес эрхлэгчдийг бий болгоход оршино.

1.2.1.3. Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын ж заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дах хэсэг, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь-Алтай аймагт 2019 оноос “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ, “Солонго

дулааны станц” ААТҮГ, “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ, “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ, Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ хуулийн этгээдийг шинээр байгуулсан. Эдгээр хуулийн этгээдийн шинээр бий болгох хэрэгцээ шаардлага, түүнд хийсэн тооцоо судалгаа, үйл ажиллагааг хөгжүүлэх хэтийн бодлого байхгүй байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дүрмийн 5.11-т “газар нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд нийцсэн хөгжлийн төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг 4 жил тутам батлуулж, мөрдөх хугацааг дүрэмдээ тусгаж өгнө” гэж заасан. Гэвч компаниуд хөгжлийн төлөвлөгөөгүй байна.

1.2.1.4. Орон нутгийн төсвөөс УТҮГ-т 2019-2021 онуудад 3,636.8 сая төгрөгийн дэмжлэг олгосон ба энэ нь нийт орлогын 70-100 хувийг эзэлж байна. Тухайлбал:

- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-т 2,053.8 сая төгрөгийн
- ✓ “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ-т 150.0 сая төгрөгийн
- ✓ “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-т 237.1 сая төгрөгийн
- ✓ “Нийтлэг үйлчилгээ” УТҮГ-т 1,069.3 сая төгрөгийн
- ✓ “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ-т 126.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Дээрх УТҮГ-ууд өөрийн орлого олох боломж бага, цаашид байнга орон нутгийн төсөвт дарамт учруулан, төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа нь байгууллагын үйл ажиллагаа хөгжихгүй, эдийн засгийн өсөлт хөгжил, үр ашиг нэмэгдэх боломжгүй байна. Иймд УТҮГ-ын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, өөрийн орлогоор үйл ажиллагаа явуулах, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх боломжийг судлан тооцоолж, стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллахаар байна.

1.2.2 3Г-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах” зорилтын хүрээнд ажил төлөвлөж, бүрэн хангагдаж байна.

1.2.2.1. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана” гэж төлөвлөсөн.

1.2.2.2. Монгол Улсын Их хурлын 2016 оны “Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын 3-т¹-т заасны дагуу үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон байна.

1.2.2.3. Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.4-т “Орон нутгийн өмчийн эзэмшилт ашиглалт, өмч хувьчлалын бодлого, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудын ашигт ажиллагааг сайжруулна”, “Өмч эзэмшилт, ашиглалтын гэрээг шинэчлэн байгуулж, жил бүр дүгнэн, түүнд хяналт тавина” 2.1.5-т “Төрийн болон орон нутгийн өмчийг мэдээлэлжүүлэх системийг нэвтрүүлэн цахим орчинг бий болгоно”, “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын удирдлага менежментийг сайжруулж, “Жишиг дүрэм”-ийг боловсруулж, ашигтай ажиллуулна” гэсэн арга хэмжээ төлөвлөжээ.

1.2.2.4. Дээрх зорилтын хүрээнд аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой болон төсөвт үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулах, алдагдлыг бууруулах зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 56 дугаар тогтоолоор “Үйлдвэрийн газруудын жишиг дүрэм”-ийг, 2021 оны 28 дугаар тогтоолоор “Аж ахуйн тооцоотой болон улсын төсөвт үйлдвэрийн газруудтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг тус тус батлуулан, жил бүр контракт /гэрээ/ байгуулах, биелэлтийг дүгнэх, жил бүрийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт

¹ 3.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монгол банкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

зорилтод түвшний төлөвлөгөө саналыг нь хүлээн авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Эдгээр шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор жил бүр үйлдвэрийн газруудын гэрээ, контрактныг дүгнэн, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд тайлагнан ажиллаж байна.

1.2.3 3Г-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.2.3.1. УИХ-ын 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж тус тус заасан байна.

1.2.3.2. Монгол Улсын Их хурлын 2020 оны “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын 4-т² заасны дагуу үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосон байна.

1.2.3.3. Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т “Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна”, 3.2.1-т “Орон нутгийн өмчид бүртгэлтэй илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн, эдийн засгийн эргэлтэд оруулж үр өгөөжийг нэмэгдүүлнэ”, 3.2.2-т “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын удирдлага, менежментийг сайжруулна” гэсэн арга хэмжээ төлөвлөжээ.

1.2.3.4. Зорилтын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийн судалгаа мэдээллийг жил бүр гарган, өмч эзэмшигч байгууллагын санал хүлээн авч, судлан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ 2018 онд хийгдсэнтэй холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн газрын үнэлж, санхүүгийн тайлан баланст бүртгэсэн байна. Эдгээр ажлын биелэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнасан байна.

1.2.4 Орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг дүгнээгүй байна.

1.2.4.1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолоор “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан байна. Уг дүрэмд орон нутгийн өмчит ААТҮГ-ын даргын эрх үүрэг хариуцлагын хэмжээ, эд хөрөнгийн үүрэг хариуцлагын хэмжээ, үйлдвэрийн газрын орон тоо бүтэц, цалин тогтоолтыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан байна.

1.2.4.2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор аймгийн “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, гэрээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан.

1.2.4.3. “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төсөвт үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1-т “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон

² Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллахыг Монгол банкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох бусад байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

төсөвт үйлдвэрийн газрын ерөнхий захирал, гүйцэтгэх захиралтай контрактыг дараа оны контрактыг дүгнэж, шинэчлэн байгуулах хүртэл 1 жилийн хугацаагаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна”, 2.2-т “ОНӨААТҮГ болон ТҮГ-ын захиралтай аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Орон нутгийн өмчийн газрын дарга контракт байгуулна”, 3.5-т “Ажлын хэсэг контрактыг эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны сүүлчийн 2 жилийн үзүүлэлт болон хавсралтад заасан үзүүлэлтээр тус тус дүгнэнэ” гэж заасан.

1.2.4.4. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолоор “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм”-ийн 7.1-т “Аймгийн Засаг дарга нь үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх” гэж заасан.

Хүснэгт-2 Хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ, дүгнэсэн байдал

ДД	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	“Говь-Алтай АЗЗА” ХК	96.7% сайн	97.1% сайн	83.9% хангалттай
2	“Ундарга-Алтай” ААТҮГ	дүгнээгүй	85.6% хангалттай	дүгнээгүй
3	“Алтай хотын тохижилт үйлчилгээний	дүгнээгүй	дүгнээгүй	дүгнээгүй
4	“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ	дүгнээгүй	дүгнээгүй	дүгнээгүй
5	“Суурин дулаан” ААТҮГ			дүгнээгүй
6	“Солонго дулааны станц” ААТҮГ	74.5% хангалтгүй	дүгнээгүй	дүгнээгүй
7	Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ	87.0% хангалттай	дүгнээгүй	дүгнээгүй
8	Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ	96.5% хангалттай	дүгнээгүй	дүгнээгүй
9	“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн			дүгнээгүй
10	“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ			дүгнээгүй
11	“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ	81% хангалттай		дүгнээгүй
12	Алтай хотын цогц үйлчилгээний газар”			дүгнээгүй

Эх сурвалж: Хуулийн этгээдээс

1.2.4.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захиралтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй зөрчилд 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн. Тухайлбал:

- ✓ “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” ТӨҮГ-ын удирдлагатай гэрээ байгуулаагүй, аймгийн ИТХ-ын батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг дүгнээгүй.
- ✓ “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ, “Суурин дулаан” ААТҮГ, Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ, Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ, “Нийтлэг үйлчилгээ” ААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлээгүй.
- ✓ “Суурин дулаан” ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг төлөвлөгөөг тус оны 12 дугаар сард баталж өгсөн.

1.2.4.4. Өгөгдсөн зөвлөмжийн дагуу “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ, “Ундарга-Алтай” ААТҮГ, “Суурин дулаан” ААТҮГ, “Эрдэнэ сумын эрчим хүч” ААТҮГ, Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын захирал нартай 2021 онд байгуулсан контрактыг аймгийн Засаг даргын 2022 оны А/249 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дүгнэж байгаа бөгөөд контрактын биелэлтийн дүн болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн талаар аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 417 тоот албан бичиг ирүүлсэн.

1.2.4.5. Аймгийн ИТХ-аас баталсан бүтэц орон тоо баталсан тушаал, компанийн дүрэм хоорондоо уялдаагүй байна. Тухайлбал “Ундарга-Алтай” ААТҮГ-ын дүрэмд эрх бүхий албан тушаалтан борлуулалтын менежер байна гэж заасан боловч бүтэц орон тоо баталсан тушаалаар борлуулалтын менежерийг хассан, хэмнэлтийн горим зөрчин дэд захирал албан тушаалыг нэмж баталсан байна.

1.2.4.6. “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн ТУЗ-ийг 2021 оны 24 дүгээр тогтоолоор дарга, гишүүн-9, нарийн бичгийн дарга нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Энэхүү ТУЗ-ын

дарга, гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8³ дахь заалтын дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. Бусад орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын хувьд ТУЗ-гүй байна.

1.2.4.5. Өнөөгийн байдлаар олон улсын байгууллагуудын туслалцаатайгаар компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулдаг байгууллагууд бий болон сургалт явуулж байна. Эдгээрт ТУЗ-ын дарга, гишүүдээс гадна компанийн гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудаа хамруулж, компанийн засаглалтай холбоотой асуудлаар тодорхой мэдлэгтэй болгох нь компанийн үйл ажиллагааг ёсоор нь зөв удирдан явуулахад чухал ач холбогдолтой байна.

1.2.1.6. ТУЗ болон түүний гишүүдийн тухайн жилд хийсэн ажлыг дүгнээгүй байна. ТУЗ-ийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх нь түүний ажлын хариуцлагыг дээшлүүлэх, үйл ажиллагааг сайжруулах үндэс болох учраас тодорхой хугацаанд түүний үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүний талаар дүгнэлт өгдөг тогтолцоог бий болгох нь зүйтэй.

БҮЛЭГ 2: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай байгаа эсэх

Хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөн, хянаж, батлуулан, зорилтот түвшнийг хангаж, үр ашигтай ажиллуулах шаардлагатай байна.

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж баталсан эсэх

2.1 Аймаг, сумын Засаг дарга харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний шалгуурыг батлах, дүгнэх ажил хангалтгүй байна.

2.1.1. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3.к⁴-д заасны дагуу аймаг, сумын ИТХ-аас харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг батлах зохицуулалттай. Харин аймаг, сумын ИТХ-аас батлах энэхүү шалгуур үзүүлэлтийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын биелэлтийг тооцох шалгуур үзүүлэлт болгож, контрактад тусгахаар байна.

2.1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3⁵, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн тооцоот газрын үлгэрчилсэн дүрэм" -ийн 7.3⁶-т заасны дагуу хуулийн этгээдийн 2019-2021 оны бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн ИТХ-аар батлуулаагүй байна. Үүнд:

- ✓ "Ундарга-Алтай" ААТҮГ нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2019, 2021 оны гэрээний биелэлтийг дүгнээгүй, 2020 онд 86.5 хувьтай дүгнэсэн. Харин бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг жил бүр боловсруулсан боловч ИТХ-аар батлуулаагүй.
- ✓ "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан гэрээг 2020, 2021 онд дүгнээгүй, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлээгүй, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж өгөөгүй байна.
- ✓ Дарив сумын "Эрчим хүч" ААТҮГ-ын 2019 оны бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн ИТХ-аар батлуулаагүй.

³ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

⁴ Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох;

⁵ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах

⁶ Газраас ирүүлсэн бизнес төлөвлөгөө, эдийн засгийн саналыг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтийг хануулж ажиллах

- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын удирдлагын зардлын дээд хязгаарыг тогтоогоогүй, бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн ИТХ-аар батлуулаагүй. Мөн гүйцэтгэх захирлын цалин, шагнал, урамшуулал, хангамж, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоож өгөөгүй байна. Энэ асуудлаар 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагад зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.
- ✓ “Суурин дулаан” ААТҮГ-ын 2020 онд сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаагүй, 2020-2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлаагүй.
- ✓ Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ нь бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн ИТХ-аар батлуулаагүй
- ✓ “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ, “Нийтлэг үйлчилгээ” УТҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж өгөөгүй байна.
- ✓ “Нийтлэг үйлчилгээ” УТҮГ нь байгууллагын 2019-2021 оны бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн ИТХ-аар батлуулаагүй.

Хүснэгт-3 Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, тайлагнал /сая.төгрөг/

№	ОНӨААТҮГ	үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он		№	ОНӨААТҮГ	үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
			төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл				төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	“Говь-Алтай АЗЗА” ТӨХК	Орлого	702.7	721.1	734.4	1,008.4	1,024.7	711.5	7	“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ	Орлого	243.5	250.9	184.7	238.2	267.0	269.8
		Зардал	698.9	715.6	729.3	995.1	1,005.8	729.5			Зардал	243.5	279.2	177.2	281.3	252.6	276.1
		Ашиг	3.8	5.5	5.1	13.3	18.9	(18.0)			Ашиг	-	(28.3)	7.5	(43.1)	14.4	(6.3)
2	“Ундарга-Алтай” ААТҮГ	Орлого	977.8	993.1	1,164.4	1,072.1	1,166.6	1,087.5	8	“Эрдэнэ эрчим хүч” ААТҮГ	Орлого	167.9	173.9	219.9	182.4	190.3	190.3
		Зардал	1,119.0	1,100.8	1,137.5	1,300.6	1,466.5	1,404.0			Зардал	166.8	172.8	217.7	180.3	215.4	215.4
		Ашиг	(141.2)	(107.7)	26.9	(228.5)	(299.9)	(316.5)			Ашиг	1.1	1.1	2.2	2.1	(25.1)	(25.1)
3	“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ	Орлого	-	506.7	-	568.9	-	978.0	9	Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ	Орлого					175.9	177.0
		Зардал	-	506.7	-	524.7	-	893.3			Зардал					150.2	140.0
		Ашиг	-	-	-	44.2	-	84.7			Ашиг					25.7	37.0
4	“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ	Орлого	17.8	14.6	172.1	237.2	155.1	166.4	10	“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв”	Орлого					222.2	239.7
		Зардал	17.5	9.6	110.8	99.6	113.6	108.1			Зардал					222.0	148.6
		Ашиг	0.3	5.0	61.3	137.6	41.5	58.3			Ашиг					0.2	91.1
5	“Суурин дулаан” ААТҮГ	Орлого			237.9	211.6	258.8	258.1	11	“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ	Орлого	346.0	339.9	417.0	429.2	342.1	413.4
		Зардал			231.1	273.2	340.2	301.3			Зардал	338.0	344.7	438.6	517.1	337.1	602.8
		Ашиг			6.8	(61.5)	(81.4)	(43.2)			Ашиг	8.0	(4.8)	(21.6)	(87.9)	5.0	(189.4)
6	“Солонго дулааны станц” ААТҮГ	Орлого	403.1	331.3	592.2	469.0	706.1	768.8	12	Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ	Орлого					-	176.7
		Зардал	555.2	424.3	748.5	547.4	933.1	918.7			Зардал					-	176.1
		Ашиг	(152.1)	(93.0)	(156.3)	(78.4)	(227.0)	(149.9)			Ашиг					-	0.6

Эх сурвалж: Хуулийн этгээдийн тайлангаас

2.1.3.Эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүй байна. Тухайлбал:

- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ нь 2019 онд эдийн засгийн зорилтот түвшинг хянуулахаар хүргүүлээгүй 2020-2021 онд хүргүүлсэн. Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс 2020-2021 онд тухайн байгууллагын хүргүүлсэн саналаар төсвийг хянаж, ИТХ-д хүргүүлсэн гэх боловч нотлох баримтгүй байна. Нийт орлогыг 2020 онд 1,166.6 сая төгрөгөөр, зардлыг 1,154.2 сая төгрөгөөр хүргүүлэн, хянуулсан ба ИТХ-аас батлахдаа зардлыг 16.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Мөн 2021 онд тухайн байгууллагын хүргүүлсэн саналаар, хянаж баталсан байна. Орлого, зардлыг нэмж, хасаж батлахдаа шалтгаан тодорхой бус, тооцоо судалгаа хангалтгүй, нотлох баримтгүй байна.
- ✓ Нийт орлогыг батлагдсанаас 2019 онд 15.3 сая төгрөгөөр давуулан, 2020 онд 92.3 сая төгрөг, 2021 онд 79.1 сая төгрөгөөр тус тус тасалсан байна. Нийт зардал батлагдсанаас 2019 онд 18 сая төгрөг, 2021 онд 62.6 сая төгрөгөөр тус тус хэмнэн, 2020 онд 163.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасныг зөрчсөн.
- ✓ Ундарга-Алтай” ААТҮГ-ын эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 2019-2021 онд 801.4 сая төгрөгөөр удирдлагын зардлыг хэтрүүлсэн.
- ✓ “Суурин дулаан” ААТҮГ нь эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 2020 онд 47.5 сая төгрөгөөр удирдлагын зардлыг хэтрүүлсэн.
- ✓ “Солонго дулааны станц” ААТҮГ нь эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс орлогыг 2019 онд 7.4 сая төгрөгөөр, 2020 онд 13.1 сая төгрөгөөр, 2021 онд 6.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж алдагдалтай ажилласан.
- ✓ Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын Эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 2019-2021 онд 62.2 сая төгрөгөөр удирдлагын зардлыг хэтрүүлсэн.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн эсэх

2.2 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орлогын бүрдэлт орлогын бүрдэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

2.2.1 Хуулийн этгээдүүд төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.2.1.1. “Говь-Алтай АЗЗА” ТӨХК нь төлөвлөсөн орлогоо 2019 онд 18.4 сая төгрөгөөр, 2020 онд 274.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, 2021 онд 313.2 сая төгрөгөөр тасалсан байна. 2020 онд орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь А-0303 Алтай-Баянхонгор чиглэлийн 3 км хатуу хучилттай авто замын дагуу замын хашлага шинээр суулгаж, Алтай хот-Хүнхэр чиглэлийн 8 км хайрган замын хашлага шинээр суулгаж, Алтай хот-Хүнхэр чиглэлийн 8 км хайрган замын барилгын ажлуудыг тус тус гүйцэтгэсэнтэй холбоотой. Харин 2021 онд зөвхөн улсын чанартай авто замын засвар, арчлалтын ажлыг хийж гүйцэтгэснээс бусад эх үүсвэрээр ажил гүйцэтгээгүйгээс орлого тасарсан байна.

2.2.1.2. “Ундарга-Алтай” ААТҮГ нь 2019-2020 онд гүний худгийн эх үүсвэрээс усны хэрэгцээг хангаж байсан бөгөөд 1 хоногт 3000 м3 ус гаргах хүчин чадалтай байна. Гүйцэтгэлээр 1 хоногт 1800м3 ус гаргаж, хүчин чадлын 60 хувийг ашиглаж байсан бол 2021 онд “Тайшир-Алтай” төслийн хүрээнд Тайшираас цэвэр усны шугам татаж, хүчин чадал 4100м3 болж өссөн байна. Ингэснээр хүчин чадлын 43 хувийг ашиглаж байна.

“Ундарга-Алтай” ААТҮГ нь төлөвлөсөн орлогоо 2019 онд 15.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн бол 2021 онд 92.3 сая төгрөг, 2021 онд 79.1 сая төгрөгөөр тасалсан ба 2021 оны эцэст 132.6 сая төгрөгийн усны төлбөрийн авлагатай байна. Орон сууцны айл өрхийг тоолууртай, тоолуургүйгээр ялган ногдуулалтыг тулган баталгаажуулахад:

- ✓ Ам бүлийн тоогоор орон сууцны айл өрхийн усны орлогын ногдуулалтыг хүн амын статистик тоо мэдээлэлтэй тулгахад 2022 оны 1-5 сарын байдлаар 211 хүнээр буюу 10.5 сая төгрөгийн ногдуулалтыг дутуу хийсэн, нийт тоолууртай айл өрхийн 13 хувьд буюу 169 айлд огт ногдуулалт хийгээгүй байна.
- ✓ Аудитаар тоолууртай байгууллагын үйл ажиллагаанд ажиглалт хийхэд 2 авто угаалгын газар 268м3 буюу 1.8 сая төгрөгийн усны төлбөрийг төлөөгүй, 5 байгууллага тоолуургүй ус хэрэглэсээр байна.
- ✓ Аудитаар тоолууртай 7 байгууллагын тоолуурын эхний заалт 2022 оны 06 сарын 20-ны өдрийн заалтаас 2-13м3-аар их байна.

2.2.1.3. Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэж заасан. “Алтай орон сууцны корпорац” ААТҮГ нь 2021 онд гэрээнд заасан хуваарьт хугацаанд төлөгдөх үндсэн болон түрээсийн төлбөрөөс 208.4 сая төгрөгийг төлүүлээгүй. Иргэдээс зогсоолын төлбөр 0.7 сая төгрөгийг, сууц эзэмшигчдийн хураамж 0.5 сая төгрөгийг дутуу төлүүлсэн.

Мөн Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.3-т "Түрээслээд өмчлөгч нь гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу сарын нийт төлбөрөө төлөөгүй тохиолдолд хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг "АСОК" ААТҮГ-т төлнө" гэж заасан боловч гэрээт хугацаанд төлөгдөөгүй үндсэн төлбөрт алданги тооцоогүй.

2.2.1.4. “Солонго дулааны станц” ААТҮГ нь орлогын төлөвлөгөөгөө 2019 онд 71.8 сая төгрөг, 2020 онд 123.2 сая төгрөгөөр тасалсан, 2021 онд 62.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Солонго хорооллын 200 айл өрх, хөгжил хорооллын 7-10 гудамжны 148 айл өрх, жаргалан апартаментын 49 айл өрх, 11 дүгээр байрны 20 айл өрх, 4 аж ахуй нэгж, 8 төсөвт байгууллагыг халаалтаар ханган ажилладаг. Мөн Солонго хорооллын 200 айл өрхийг хэрэглээний халуун усаар хангадаг. 2021 оны байдлаар үйлчилгээний төлбөрөөс 26.5 сая төгрөгийг дутуу төлүүлсэн.

2.2.1.5. Мөн “Суурин дулаан” ААТҮГ нь 15.4 сая төгрөгийн, Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ 7.2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг батлахдаа хэрэглэгчийн судалгаанд үндэслэсэн борлуулалтын орлого, нийт зардлаас нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авалт хийх зардлын дүн, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүнг заавал тусгаж бодит хэрэгжилтийг тооцсоноор үйл ажиллагааны үр дүн сайжрахдаа байна.

2.2.2 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн ногдуулалт, төвлөрүүлэх үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас хяналт огт тавиагүй, айл өрх болон аж ахуй нэгж байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй, дутуу төвлөрүүлэлт их хэмжээгээр үүссэн байна.

2.2.2.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2019-2021 онуудад татварт нийт 1,318.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

2.2.2.2. Байгууллагын санхүүгийн тайлан дахь татварын өглөг авлага нь татварын тодорхойлолтоос 85.6 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Мөн татварын тайлангийн орлогын дүн нь нягтлан бодох бүртгэлийн тайлагнавал зохих дүнгээс 42.9 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Тухайлбал:

- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ-ын татварын тодорхойлолт санхүүгийн тайлангаас зөрүүтэй байна. Тухайлбал: 2021 онд ихээхэн хэмжээний зөрүүтэй байгаа нь Татварын хэлтсээс тогтоосон НА-05210000012 дугаартай нөхөн ногдуулалтын акт /36.5 сая төгрөгийн ус бохирдуулсны төлбөр, 14.6 сая төгрөгийн торгууль, 2.6 сая төгрөгийн алданги нийт 53.6 сая төгрөгийн татварын төлбөр/ тогтоосонтой холбоотой байна. Энэ асуудлаар тухайн байгууллага Шүүхэд хандсан боловч анхан шатны Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон байна. Одоогоор давж заалдах шатны Шүүхэд хандсан байна.
- ✓ Тухайн байгууллага татварын тодорхойлолтоор НӨАТ-ын татварыг 33.7 сая төгрөгөөр илүү төлсөн, ХХОАТ-ыг 5.7 сая төгрөгөөр, агаарын бохирдлын татварыг 0.2 сая төгрөгөөр, АТӨЯХАТ-ыг 0.7 сая төгрөгөөр, татварын төлбөр, торгууль, алдангийг 53.6 сая төгрөгөөр дутуу бусад төрлийн татвар хураамжийг дутуу төлсөн харагдаж байна.

Дээрх зөрчлийн хувьд нэгж байгууллагад 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэр өгөгдсөн.

2.2.2.3. “Алтай хотын тохижилт үйлчилгээ” ААТҮГ-ын дүрэмд зааснаар Алтай хотын нийтийн эзэмшлийн зам талбайн удирдан зохион байгуулагч бөгөөд дараах үйл ажиллагааг эрхэлдэг. Үүнд:

- ✚ Алтай хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн болон дахиварын сав байршуулах, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх
- ✚ Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуй нэгжүүд болон бусад харилцагчийн хог хаягдлыг тогтоосон хугацаанд төлбөртэй ачиж тээвэрлэх
- ✚ Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хариуцах
- ✚ Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, ус зайлуулах суваг шуудууны цэвэрлэгээ, гудамж талбайд хөшөө, дурсгал чимэглэлийг шинээр хийх, арчлах,
- ✚ Авто зам, явган замын арчлалт, нохой устгал,
- ✚ Нийтийн эзэмшлийн тавилга, тоглоомын талбайн арчлалт

Дээрх чиглэлийн хүрээнд ихэнх үйлчилгээ нь нийтийн эзэмшлийн зам, талбайд хийгдэж байгаа учраас төлбөр хураамжгүй, өөрийн орлого олж үйл ажиллагаандаа зарцуулах боломжгүй байна.

Тухайн байгууллагын үзүүлж буй үйлчилгээнээс зөвхөн хог хаягдлын үйлчилгээ төлбөртэй үзүүлж айл өрх болон албан байгууллага, аж ахуй нэгж байгууллагуудаас хогны төлбөр хураамж авдаг боловч Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.12 дахь заалтад “хог хаягдлын үйлчилгээний хураамж” гэсэн заасны дагуу тус байгууллага нь зарцуулах эрхгүйн улмаас хураасан орлого нь сумын орон нутгийн татварын орлогод бүрэн төвлөрч байна.

Хогны төлбөр хураамжийн тухайд 2019 онд 108.2 сая төгрөг, 2020 онд 107.2 сая төгрөг, 2021 онд 120.2 сая төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 2019 онд урсгал зардалд 506.7 сая төгрөг, 2020 онд урсгал зардалд 568.9 сая төгрөг, 2021 онд урсгал зардалд 635.9 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын зардалд 342.1 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн ногдуулалт, төвлөрүүлэх үйл ажиллагаанд дээд шатны байгууллагаас хяналт огт тавиагүй, айл өрх болон аж ахуй нэгж байгууллагын тооцоо нийлж баталгаажуулаагүй дутуу төвлөрүүлэлт их хэмжээгээр үүссэн байна. Тухайлбал:

- ✓ Айл өрхийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөх 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны төлбөрийг 23.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.
- ✓ Орлогын байцаагч айл өрхөөс бэлнээр хураасан хогны төлбөрөөс 0.4 сая төгрөгөөр орон нутгийн орлогын дансанд дутуу тушаасан.
- ✓ Жижиг аж ахуй нэгж байгууллагын хогны төлбөр хураамж 2.1 сая төгрөгөөр дутуу төлөлттэй, хаагдсан болон үйл ажиллагаа нь зогссон жижиг дэлгүүр, аж ахуй нэгжийн хогны төлбөрийн дутуу төлөлт 2019 оны үлдэгдлээр 2.2 сая төгрөг байна.
- ✓ Хогны төлбөр, хураамж 2.4 сая төгрөгийн орлогыг цаг тухайд нь бүрэн төвлөрүүлээгүй.
- ✓ “АУЭХС” ТӨХК нь гэрээний дагуу айл өрхийн хогны хураамжийн ногдуулалтаас 0.6 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
- ✓ Айл өрхийн хогны төлбөрийг тулгахад 5.9 сая төгрөгийн илүү төлөлттэй тооцоо гарч байгаа нь бодитоор байхгүй үндэслэлгүй бөгөөд ногдуулалтыг бүрэн хийхгүй байна.
- ✓ Айл өрхийн хогны төлбөрийг тулгахад 165.5 сая төгрөгийн авлагын тооцоо гарсан бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- ✓ Есөнбулаг сумын Засаг дарга нь АУЭХС ТӨХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, цахилгааны мөнгөтэй хамт хураасан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 15 хувийг ажлын хөлс болгохоор гэрээнд тусгасан. Улмаар “АУЭХС” ТӨХК нь 2019, 2020 онд хог хаягдлын хураамжаас нийт 21.9 сая төгрөгийг суутгаж тооцсон.

АУЭХС ТӨХК-тай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж 2020 оны 12 сар хүртэл хогны төлбөр хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган нэхэмжилж төлүүлсэн байна. Цахилгааны төлбөртэй хамтатган нэхэмжилж төлүүлсэн хугацаа буюу 2019, 2020 онд АУЭХС ТӨХК нь нийт 146.9 сая төгрөг нэхэмжилж, 146.4 сая төгрөг төлүүлсэн нь 99.7 хувийн биелэлттэй. Харин “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ нь тухайн онуудад айл өрхөд 138.1 сая төгрөг ногдуулж, 68.5 сая төгрөг төлүүлж 49.6 хувийн биелэлттэй байгаа нь харьцангуй төлөлт муу байна.

Мөн аудитын явцад айл өрхөөс санамсаргүйгээр сонгож уулзалт хийхэд тухайн айл өрх хашаандаа бараг байдаггүй, хөдөө байдаг, байранд нүүсэн гэх мэтчилэн шалтгаан тайлбар их тавьж байгаагаас үзэхэд биеэр яваад ногдуулалтыг бүрэн барагдуулах нь хүндрэлтэй харагдаж байна.

Иймээс Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно” гэж заасны дагуу хогны төлбөр хураамжийг бусад хэрэглээний зардалтай хамтатган нэхэмжилж төлүүлэх нь төлөлтийг эрс сайжруулж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх сайн талтай байна.

Урт хугацаат өр төлбөр, Зээлийн талаар:

2.2.2.4. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, “Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ байгуулагдсан байна.

Монгол Улсын ЗГ-ын 2019 оны 223 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын хөгжлийн банк болон Говь-Алтай аймгийн Засаг дарга нарын хооронд “Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах тухай” 2/68 дугаартай гэрээг 2020 оны 08 дугаар сарын 21-ны өдөр байгуулан Солонго хорооллын 120 айлын орон сууцыг орон нутгийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн.

“Алтайн орон сууцны корпораци” ААТҮГ-ын зээлийн үлдэгдэл 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар үндсэн төлбөрт 6,680.5 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 515.2 сая төгрөг, алдангийн төлбөрт 442.6 сая төгрөгийн зөрчилтэй байгаа бөгөөд энэ өдрийг хүртэлх хугацаанд үндсэн төлбөрт 1,150.0 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 459.5 сая төгрөгийн эргэн төлөлтийг Монгол Улсын Хөгжлийн банканд хийгээд байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоолын 2-т "Хөгжлийн банканд төлөгдөх зээлийн хүүгийн төлбөр болох 1,435.7 сая төгрөгийг улс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр төлж барагдуулахыг аймгийн Засаг даргад даалгасугай" гэсэн шийдвэрийг гаргасан боловч өдий хүртэл шийдвэрлээгүй. Хөгжлийн банканд орон сууцны төлбөрийн хүүд 459.5 сая төгрөгийг Алтайн орон сууцны корпораци" ААТҮГ-ын төсвөөс төлсөн. Иймд Хөгжлийн банканд төлөх орон сууцны зээлийн хүүг төлөх хөрөнгийн эх үүсвэрийг хууль эрх зүйд нийцүүлэх шийдвэрлэх шаардлагатай байна.

Хүснэгт-4 Орон сууцны зээлийн эргэн төлөлтийн хөрөнгийн эргэцийн чадварын судалгаа /сая төгрөг/

ДД	Төлбөрийн өдөр	Хон ог	Хөгжлийн банканд төлөгдөх хуваарь			Гэрээгээр үндсэн төлбөрийн эргэн төлөгдөх хуваарь	Зөрүү /хөрөнгийн эх үүсвэрийн дутагдал-, илүү+
			Үндсэн төлбөрийн үнэ	Хүүгийн төлбөр	Нийт төлөх дүн		
	2019 он					1007.2	
1	11/2/2020	357	1150.0	459.5	1609.5	817.8	168.2
2	12/15/2020	43		47.2	47.2		
3	6/15/2021	182	835.1	199.9	1034.9	741.2	-1136.5
4	12/15/2021	183	835.1	175.8	1010.9		
5	6/15/2022	182	835.1	149.9	985.0	745.2	-2337.0
6	12/15/2022	183	835.1	125.6	960.7		
7	6/15/2023	182	835.1	99.9	935.0	745.2	-3437.2
8	12/15/2023	183	835.1	75.4	910.4		
9	6/15/2024	183	835.1	50.2	885.3	721.8	-4456.3
10	11/11/2024	149	835.1	20.5	855.5		
	2025 он					3052.3	-1404.0
	НИЙТ		7,830.5	1,403.9	9,234.5	7,830.5	

Хөгжлийн банкт хийсэн гэрээний зээлийн эргэн төлөлтийн хуваарийг орон сууц эзэмшигчтэй хийсэн гэрээний эргэн төлөлтийн хуваарьтай харьцуулж үзэхэд өссөн дүнгээр 2021 онд 1,136.5 сая төгрөгийн, 2022 онд 2,337.0 сая төгрөгийн, 2023 онд 3,437.2 сая төгрөгийн, 2024 онд 4,456.3 сая төгрөгийн эх үүсвэр дутагдахаар тооцоотой байна. Хөгжлийн банканд төлөх орон сууцны зээлийн төлбөр төлөх хуваарийг түрээслэгчтэй хийсэн гэрээний төлөлтийн хуваарьтай уялдуулан эдийн засгийн хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэхээр байна.

2.2.2.5. "Ундарга-Алтай" ААТҮГ-ын санхүүгийн тайланд Мон-2301, 1847 төслийн хөрөнгө оруулалттай холбоотой 4,694.4 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөр бүртгэлтэй. Уг өр төлбөрийн 4,626.4 сая төгрөг Мон-2301, 68.0 сая төгрөг Мон-1847 төслийн үлдэгдэл байна.

Мон-2301 төслийн зээлийн талаар: Шугам сүлжээг өргөтгөх зориулалтаар Сангийн яам, аймгийн ЗДТГ хоорондын дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2014-2033 оныг хамруулан үндсэн төлбөрт 3,863.3 сая төгрөг, хүүгийн төлбөрт 763.0 сая төгрөг нийт 4,626.4 сая төгрөгийг төлөхөөр байгуулжээ. 2021 оны байдлаар төлөлт огт хийгдээгүй, 1,641.9 сая төгрөгийн үндсэн төлбөр хугацаа хэтэрсэн, 307.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөөгүй байна.

Мон-1847 төслийн зээлийн талаар: Шугам сүлжээг өргөтгөх зориулалтаар Сангийн яам, аймгийн ЗДТГ хоорондын дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 2006-2025 оныг хамруулан үндсэн төлбөрт 255.2 сая төгрөг, хүүгийн төлбөрт 97.0 сая төгрөг нийт 355.2 сая төгрөгийг төлөхөөр байгуулжээ. 2021 оны байдлаар 187.5 сая төгрөгийн үндсэн төлбөрт, 92.1 сая төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн ба хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна.

Арилжааны банкны богино хугацаат өр төлбөрийн талаар: Тус байгууллага нь эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр дутагдан Хаан банкнаас 2020, 2021 онд тус бүр 30.0 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай авсан бөгөөд 2020 онд авсан 30.0 сая төгрөгийн үндсэн зээл, 0.9 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг хугацаанд бүрэн төлсөн байна. Харин 2021 онд авсан зээлийн үндсэн төлбөр 30.0 сая төгрөг, хүүгийн төлбөр 1.4 сая төгрөгийг 2022 онд төлөх хуваарьтай бөгөөд 2021 онд 0.6 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг илүү төлсөн байна.

2.2.2.6. “Говь-Алтай АЗЗА” ТӨХК нь “Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 3.4 дэх заалтыг үндэслэн Арабын эдийн засгийн Кувейтын сангийн хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжигдэн Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 166 дугаар тушаалын дагуу хуваарилагдсан 9 нэрийн 283.6 сая төгрөгийн машин механизмыг урт хугацаат өглөгөөр бүртгэсэн. Үүнтэй холбоотой гэрээ хэлцэл хийсэн баримт материал байхгүй.

2.2.2.7. “Солонго дулааны станц” ААТҮГ нь 2019 онд аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас “Инженерийн шугам сүлжээ байгуулах” төслөөр хэрэглэгчдийг дулаан хангамжаар хангах зориулалтаар аймгийн ИТХТ-ийн 2019 оны 08 дугаар сарын 01-ний 65 дугаар тогтоол гарч Засаг даргын мөн өдрийн А/385 тоот захирамжаар гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэрлэж 150.0 сая төгрөгийн зээлийг авсан байна.

Зээлийг 3 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр эргүүлэн төлөхөөр гэрээнд заажээ. Зээлийн хугацаа 2019 оны 08 дугаар сарын 02-нд эхэлж 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдөр дуусна. Гэрээний дагуу 2019 онд үндсэн төлбөр төлөөгүй хүүгийн төлбөрт 1.6 сая төгрөг, 2020 онд гэрээний дагуу үндсэн төлбөрт 34.4 сая төгрөг, хүүгийн төлбөрт 3.9 сая төгрөг, 2021 онд үндсэн төлбөрт 78.4 сая төгрөг, хүүгийн төлбөрт 2.1 сая төгрөгийг төлсөн. Гэвч 2020 оны зээлийг гэрээний хугацаанд төлөөгүйн алданги 8.1 сая төгрөг тогтоогдсоныг төлөөгүй, тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Аудитаар зээлийн гэрээний дагуу 2022 оны төлбөрийг одоо болтол төлөөгүй байгаа нь гэрээний үүргээ биелүүлээгүй байна гэж үзлээ. Аудитаар 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар үндсэн төлбөрт 31.9 сая төгрөг, хүүгийн төлбөрт 0.3 сая төгрөг төлөхөөр байгаа бөгөөд төлөгдөөгүй үүргийн дүнд гэрээнд заасны дагуу 14.6 сая төгрөгийн алданги тооцогдохоор байна.

2.2.2.8. Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь 2019-2021 оны байдлаар 156.5 сая төгрөгийн зээлийг үйлдвэрлэлийг тогтвортой явуулах зорилгоор авсан бөгөөд үүнээс 115.0 сая төгрөгийн зээлийг хугацаанд нь төлж 40.7 сая төгрөгийн зээлийг гэрээний дагуу төлөгдөөгүй үлдэгдэлтэй өглөгөөр тайлагнасан байна. Мөн үүнээс гадна хувь хүний нэрийн дансанд 2018 оноос хойш 83.0 сая төгрөгийг зээл болон зээлийн хүү гэж мөнгө шилжүүлсэн боловч гэрээгүй, байгууллагын 2013 оноос хойш дансны хуулгыг тулган баталгаажуулахад дансаар дамжуулаагүй бөгөөд анхан шатны баримтаар нотлохгүй байна.

Түрээсийн талаар:

2.2.2.9. “Ундарга-Алтай” ААТҮГ нь 2019 онд 3.0 сая төгрөгөөр, 2021 онд 0.5 сая төгрөгөөр том оврын экскаваторыг түрээслүүлэн, 3.5 сая төгрөгийн орлого олж, үйл ажиллагаандаа зарцуулжээ. Аймгийн ИТХ-ын 2009 оны 68 дугаар тогтоолын дагуу орон нутгийн төсөвт 1.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.2.2.10. “Алтай Усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ нь 2021 онд “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-т 37 м2 бүхий 2 өрөөг түрээслүүлж 0.7 сая төгрөгийг орлого бөгөөд аймгийн ИТХ-ын 2009 оны 68 дугаар тогтоолын дагуу төвлөрүүлсэн байна. 2022 оны эхний сараас кофе шоп, оффис өрөө, теннис, фитнес заалны зориулалтаар өрөө нийт 428.3 м2 ашигтай талбай бүхий газрыг иргэн, аж ахуй нэгжид түрээслүүлсэн хэдий ч эхний улиралд гэрээ байгуулаагүй, түрээс тооцож аваагүй байна.

Орон нутгийн өмчийн газар, Усан спорт чийрэгжүүлэлтийн газар, “Цоохор Алт” ХХК-тай фитнес заалны зориулалтаар 210 м2 талбай бүхий өрөөг түрээслүүлэх гэрээ байгуулж ажилласан хэдий тус фитнесийн ашиглаж байгаа хувцас солих өрөө, шүршүүрийн өрөө бүхий 75.8 м2 талбайн түрээсийг тооцоогүй байна.

2.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилтот түвшнийг хангаж, үр ашигтай байгаа эсэх

2.3 Хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж, үр нөлөөг дүгнэхээр байна.

2.3.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн тооцоо шинжилгээг хийдэггүй, үр нөлөөг дүгнэдэггүй байна.

2.3.2. Хуулийн этгээдүүдийн санхүүгийн гол үзүүлэлтийг үндэслэн сүүлийн 3 жилээр санхүүгийн харьцааны шинжилгээ хийлээ.

Хүснэгт-5

Хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ

№	Үзүүлэлт	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК			"Ундарга-Алтай" ААТҮГ			"Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ			"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ			"Суурин дулаан" ААТҮГ	
		2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2020 он	2021 он
1	Эргэлтийн харьцаа	40.68	460.54	526.86	4.31	3.21	2.01	8.61	16.69	БХӨТ байхгүй	22.3	12.1	14.5	БХӨТ байхгүй	21.16
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	27.47	319.31	382.82	3.42	2.79	2	1.0	7.0	БХӨТ байхгүй	21.2	11.5	14	БХӨТ байхгүй	16.60
3	Дансны авлагын эргэц /удаа/	137.27	221.31	159.03	2.26	1.46	1	Зээлээрх борлуулалт байхгүй			1.16	0.86	0.87	282	100.44
4	Дансны авлагын эргэц /хоноогоор/	2.66	1.65	2.30	161.62	249.44	254	Зээлээрх борлуулалт байхгүй			313.6	425.5	418.5	1.28	3.58
5	Бараа материалын эргэц /удаа/	4.95	8.60	5.59	5.39	5.54	7	Бараа материалын эргэц тооцох боломжгүй			Бараа материалын эргэц тооцох			12.17	18.84
6	Бараа материалын эргэц /өдрөөр/	73.73	42.44	65.33	67.66	65.83	52	Бараа материалын эргэц тооцох боломжгүй			Бараа материалын эргэц тооцох боломжгүй			29.58	19.110
7	Өрийн харьцаа	0.25	0.24	0.24	0.81	0.81	1	0.05%	0.07%	0%	0.999	0.98	0.97	Өр төлбөр байхгүй	0.001
8	Хүү төлөх чадвар	0.00	0.00	0.00	Алдагдалтай			Зээлгүй, хүүгийн зардал гарахгүй			Хүү төлөх чадваргүй, гэрээнд тусгаагүй			Зээлгүй, хүүгийн зардал гараагүй	0.001
9	Ашгийн түвшин	0.01	0.01	-0.03	Алдагдалтай			Алдагдалтай			0.3	0.6	0.4	Алдагдалтай	-0.060
10	Хөрөнгийн эргэц	0.56	0.85	0.61	Алдагдалтай			Алдагдалтай			0.002	0.03	0.02	Алдагдалтай	-0.008
11	Хөрөнгийн өгөөж	0.003	0.010	-0.03	Алдагдалтай			Алдагдалтай			0.001	0.02	0.01	Алдагдалтай	-0.008
12	Энгийн хувьцаа эзэмшигчдийн өгөөж														
13	Нэгж хувьцаанд ногдох ашиг	3.96	11.77	Алдагдалтай											
14	Үнэ ашгийн харьцаа	0.00	0.00	0.00											
15	Ногдол ашиг олголтын харьцаа	0.15	0.10	0.00											

№	Үзүүлэлт	"Солонго дулааны станц" ААТҮГ			"Дарив сумын эрчим хүч" ААТҮГ			"Эрдэнэ эрчим хүч" ААТҮГ			"Алтай усан спорт чийрэгжүүлэлт ийн газар" УТҮГ	"Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ	"Нийтлэг үйлчилгээ" УТҮГ			Алтай хотын цогц үйлчилгээний газар" УТҮГ
		2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2021 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2021 он
1	Эргэлтийн харьцаа	0.76	1.90	1.22	0.348	4.1	0.9	0.79	2.15	0.63	БХӨТ байхгүй	БХӨТ байхгүй	2.10	1.13	1.14	1.2
2	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	0.04	0.22	0.13	0.127	0.25	0.210	0.003	0.02	0.09	БХӨТ байхгүй	БХӨТ байхгүй	1.45	0.82	0.74	1.2
3	Дансны авлагын эргэц /удаа/	22.48	8.42	8.0	5.77	2.7605	4	3.163			Дансны авлагагүй	Дансны авлагагүй	2.79	3.44	3.44	Авлага байхгүй
4	Дансны авлагын эргэц /хоноогоор/	16.24	43.37	47.0	63	132.2	95	12.17	12.17	12.17	Дансны авлагагүй	Дансны авлагагүй	130.73	106.2	106.10	Авлага байхгүй
5	Бараа материалын эргэц /удаа/	29.62	10.21	4.0	Бараа материал борлуулаагүй			1.90	1.80	2.22	Бараа борлуулаагүй	Бараа борлуулаагүй	0.00	8.68	0.00	Бараа материалын эргэц тооцох боломжгүй
6	Бараа материалын эргэц /өдрөөр/	12.32	35.74	82.0	Бараа материал борлуулаагүй			91.25	91.25	91.25	Бараа борлуулаагүй	Бараа борлуулаагүй	0.00	42.03	0.00	Бараа материалын эргэц тооцох боломжгүй
7	Өрийн харьцаа	0.18	0.04	0.02	0.28	0.2	0.3	0.19	0.04	0.27	өр төлбөргүй	өр төлбөргүй	0.05	0.08	0.14	0.001
8	Хүү төлөх чадвар	Алдагдалтай			Алдагдалтай						өр төлбөргүй	өр төлбөргүй	Алдагдалтай			Тооцох боломжгүй
9	Ашгийн түвшин	Алдагдалтай			Алдагдалтай ажиллаж байгаа тул ашигт ажиллагааг тооцох боломжгүй			0.01	0.01		2.00	Нийт орлогын 1 хувийг өөрийн орлого бүрдүүлж, 99 хувийг төсвөөс дэмжлэг авч үйл ажиллагаа явуулж байна.	Алдагдалтай			0.01
10	Хөрөнгийн эргэц	Алдагдалтай						1.10	1.02	1.28	0.01		Алдагдалтай			0.03
11	Хөрөнгийн өгөөж	Алдагдалтай						0.01	0.01		0.02		Алдагдалтай			0.0003

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үзүүлэлтэд хийсэн шинжилгээнээс дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ✓ "Алтай хотын тохижилт үйлчилгээний газар" ААТҮГ: Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар 2019-2021 онд нэмэгдсэн байна. Нийт хөрөнгийн 2019-2021 онд 1 хувь хүрэхгүй өр төлбөртэй байгаа нь урт хугацааны туршид төлбөрийн чадварын харьцаа сайн байна.

- ✓ **“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар сүүлийн гурван жил сайн байна. Ойрын хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө нэмэгдсэн байна. Авлага цуглуулах давтамж, хугацаа бага байгаа нь төлөгдөх үндсэн болон түрээсийн төлбөр бүрэн барагдаагүйтэй холбоотой. Нийт хөрөнгийн 97-99 хувийг орон сууц, зогсоолын үнэ болох 7,830.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд төлөхөөр урт хугацаат өглөг эзэлж, хүү төлөх чадваргүй, гэрээнд тусгаагүй байна үүнээс үзэхэд урт хугацааны туршид оршин тогтнох төлбөрийн чадвар муу хэт их өр зээлийн дарамтад орох, зээлийн болон хүүгийн төлбөрөө төлөх боломжгүй болох эрсдэл өндөртэй байна. Тус компанийн тодорхой хугацааны ашгийг хэмжихэд хөрөнгөө ашиглаад олж байгаа цэвэр ашиг, 1 төгрөгийн борлуулалтад эзлэх цэвэр ашиг бага ашигт ажиллагаа муу байна.
- ✓ **Суурин дулаан ААТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвартай, ойрын хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө их, дансны авлагаа цуглуулах давтамж нь 2020-2021 онд сайн боловч авлага цуглуулах хоногийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад өссөн байна. Нийт хөрөнгийн нэг хувийг өр эзэлж байна. Энэ нь урт хугацааны туршид төлбөрийн чадварын харьцаа сайн. Ашигт ажиллагааны хувьд сүүлийн 2 жил алдагдалтай ажилласан боловч 120 хүүхдийн дотуур байр ашиглалтад ороход алдагдлын хэмжээ буурахаар байна.
- ✓ **“Солонго дулааны станц” ААТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар сайн. Ойрын хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө сүүлийн 3 жил бага байна. Авлага цуглуулах давтамж бага байна. Нийт хөрөнгийн 2019-2021 онд 2-18 хувийг өр төлбөр эзэлж байна. Өрийн харьцаа буурсан үзүүлэлттэй байгаа нь компанийн урт хугацааны туршид оршин тогтнох төлбөрийн чадварын харьцаа сайн байна. Алдагдалтай ажилласан тул ашигт ажиллагаа муу байна.
- ✓ **Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар муу, ойрын хугацаанд мөнгө болох чадварын хөрөнгө бага байна. Авлага цуглуулах давтамж, хугацаа бага байна. Нийт хөрөнгийн 2-28 хувийг өр төлбөр эзэлж байна. Зээлийн гэрээ байхгүй, хүү төлөх чадварыг тооцох боломжгүй. Алдагдалтай ажилласан байна.
- ✓ **Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар 2019, 2021 онд муу байна. Ойрын хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө бага байна. Бараа материалын эргэц муу байна. Нийт хөрөнгийн 4-27 хувийг өр төлбөр сүүлийн 3 эзэлж байна. Энэ нь Компанийн урт хугацааны туршид оршин тогтнох төлбөрийн чадварт анхаарах хэрэгтэй. Нэг төгрөгийн борлуулалтад эзлэх цэвэр ашгийн хэмжээ бага байна. Борлуулалт хийхийн тулд хөрөнгөө үр ашигтай ажилласан байна. Тодорхой хугацааны ашигт ажиллагааг үзэхэд бага байна.
- ✓ **“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ:** 2021 онд шинээр үүсгэн байгуулагдсан байгууллагын хувьд богино хугацаат өр төлбөр, дансны авлагагүй байна. Байгууллагын тодорхой хугацааны ашгийг хэмжихэд 1 төгрөгийн борлуулалтад эзлэх цэвэр ашгийн хувь бага, борлуулалт хийхийн тулд хөрөнгөө үр ашигтай ашигласан.
- ✓ **“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ:** 2021 онд шинээр үүсгэн байгуулагдсан байгууллагын хувьд богино хугацаат өр төлбөр, дансны авлагагүй байна. Тодорхой хугацааны ашигт ажиллагаа бага байна.
- ✓ **“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар 2020, 2021 онд муу байна. Ойрын хугацаанд мөнгө болох чадвартай хөрөнгө бага байна. Авлага цуглуулах давтамж, хугацаа сайн байна. Нийт хөрөнгийн 5-14 хувийг өр төлбөр 2019-2021 онд эзэлж байгаа нь төлбөрийн чадварт нөлөөлөхөөр байна.
- ✓ **“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ:** Эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө төлөх чадвар 2021 онд муу байна. Ойрын хугацаанд мөнгө болох чадвар сайн байна. Нийт хөрөнгөнд эзлэх өрийн харьцаа бага байна. Тодорхой хугацааны ашигт ажиллагааг үзэхэд бага байна.

2.4 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж байгаа эсэх

2.4 “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн орлогын 68 хувийг улсын төсвөөс, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн орлогын 78 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

2.4.1 Эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс удирдлагын зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

2.4.1.1. ТӨК-ууд хуульд заасны дагуу хараат бус гишүүдээс бүрдсэн ТУЗ-ийг томилдог болгох ба энэ ажиллагааг нийтэд ил тод нээлттэй явуулах ёстой. Мөн ТӨК-ийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-өөс өөрийн гишүүд болон бусад удирдлагад олгож буй цалин урамшууллыг тайлан баланст тусган нийтэд заавал мэдээлж байх ёстой. Ялангуяа ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал нь нийтэд ил тод нээлттэй байх мэдээллийн нэг хэсэг мөн.

2.4.1.2. Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.6-д “Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхээр томилогдсон этгээд Төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12⁷ дахь хэсэгт заасны дагуу цалин хөлс авна”, 3.7-д “Энэ журмын 3.6-д заасан цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэж заасан. “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд төрийг төлөөлж оролцох этгээд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бөгөөд ТУЗ-ын цалинг тогтоосон шийдвэргүйгээр зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд цалин хөлсийг олгож байна.

2.4.1.3. Хуулийн этгээдүүд нь зардлыг бөөн дүнгээр, үндэслэл тооцоо судалгаа хийгээгүй хүргүүлсэн нь удирдлагын зардлыг хэтрүүлэн зарцуулах үндэслэл болжээ. Тухайлбал: 2019-2021 онд “Ундарга-Алтай” ААТҮГ-ын 801.4 сая төгрөгөөр, “Суурин дулаан” ААТҮГ нь 2020 онд 47.5 сая төгрөгөөр, Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2019-2021 онд 62.2 сая төгрөгөөр удирдлагын зардлыг хэтрүүлсэн байна.

2.4.2 Үйл ажиллагааны зардлын төлөвлөлтийг оновчтой болгож арвиан хэмнэлттэй зарцуулах хэрэгтэй байна.

2.4.2.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хийсэн санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаар нийт 14,888.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5,866.0 сая төгрөгийн алдааг залруулсан байна. Тухайлбал:

- ✓ Орлогыг зөвшөөрөлгүй олсон, гэрээний дагуу орлогыг төлүүлээгүй, орлогын төлөвлөгөөг тасалсан, дутуу төвлөрүүлсэн нийт 891.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ✓ Батлагдсан бүтэц, орон тооноос илүү ажиллуулсан, тушаал шийдвэргүй, цалин зөрүүтэй олгосон, цалингаас зөвшөөрөлгүй суутгал хийсэн, тэтгэвэрт гарсан ажилтны тэтгэмжийг дутуу олгосон, удирдлагын буруутай шийдвэрийн улмаас төсөв хохирсон зэрэг нийт 126.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн.
- ✓ Цахилгаан, халаалт, цэвэр бохир усны төлбөрийг төрөөс 4.6 сая төгрөгөөр зөрүүтэй нэхэмжилсэн
- ✓ Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 53.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан
- ✓ И баримтгүй 506.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн
- ✓ Шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулаагүй
- ✓ Худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр 859.9 сая төгрөгийг зарцуулсан
- ✓ Авлага өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлээгүй 839.4 сая төгрөгийн
- ✓ Хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн бүртгэл зөрүүтэй, хөрөнгө дутагдсан, чанар му, ашиглалтгүй, 1,230.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн
- ✓ Хөгжлийн банкт хийсэн гэрээний дагуу 1,670.1 сая төгрөгийн эргэн төлөлтийг хийгээгүй,
- ✓ Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн зорилтот түвшинг дүгнээгүй байх, нэгжийн захиралтай байгуулсан гэрээг дүгнээгүй байх
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй
- ✓ Татварын тайланд орлогыг зөрүүтэй тайлагнасан, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнасан, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн 1,231.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

2.4.2.2. Аймгийн ИТХ-ын тогтоолоор “Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг үйл ажиллагаанд нь нийцүүлэн тогтоохыг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй” гэж заасны дагуу тухайн шатны Засаг дарга орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны норм, нормативыг баталж байна. Тухайлбал:

- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагын дагуу ажилчдын хувийн хэргийг үзэж тулгахад боловсрол зөрүүтэй 2, мэргэжил зөрүүтэй 1, мэргэшил зөрүүтэй 2, нийт 5 ажилтан ажлын байрны тодорхойлолтын дагуу шаардлага хангахгүй, 1 ажилтны хувийн хэрэгт боловсролын байдлын материал байхгүй, аудитын хугацаанд ирүүлээгүй.
- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ нь зарим албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан боловч батлаагүй, баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагын дагуу ажилчдын хувийн хэргийг үзэж тулгахад боловсрол зөрүүтэй 2, мэргэжил зөрүүтэй 6, мэргэшил зөрүүтэй 8, ажлын туршлага зөрүүтэй 6, нийт давхардсан тоогоор 13 ажилтан ажлын байрны тодорхойлолтын дагуу шаардлага хангахгүй байна.
- ✓ Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь аймгийн ИТХ-аас 14 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталж өгсөн хэдий ажиллах бүтцийг баталж өгөөгүй байна. Гүйцэтгэх захирал нь ажлын байрны тодорхойлолт ажил үүргийг хуваарийг баталж мөрдүүлээгүй, ажилтны хувийн хэрэгт анкет,

⁷ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно.

өргөдлөөс өөр зүйл байхгүй байна. Мөн уурын зуухны машинистууд нь зуух ажиллуулах зөвшөөрөлгүй, 1 слесарь нь мэргэжлийн үнэмлэхгүй ажиллаж байна. Байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй.

- ✓ “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн 1 ажилтан С ангиллын жолооны үнэмлэхгүй, 4 замчин, 1 гүүр хамгаалагч мэргэжлийн үнэмлэхгүй байгаа захирлын баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцэхгүй байна.
- ✓ “Алтай Усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ нь аймгийн ИТХ-аас 11 орон тоотой ажиллахаар баталсан 4 орон тоо илүү ажиллуулсан Үүнд Утгах ажилтан, дасгалжуулагч, харуул үйлчлэгч, гүйцэтгэх удирдлага нь Ажиллагсдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг баталж бөгөөд 10 ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод нийцэхгүй байна. Байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй.
- ✓ “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан орон тоог 4 орон тоогоор хэтрүүлэн ажиллуулсан.
- ✓ “Суурин дулаан” ААТҮГ-ын зарим албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан боловч батлаагүй, байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй, байгууллагын даргын томилогдсон тушаалгүй 10 албан хаагч, 13 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй байна.
- ✓ “Солонго дулааны станц” ААТҮГ-ын байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй, ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан боловч батлаагүй. Байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй.
- ✓ “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ-ын 10 ажилтан нь ажлын байрны тодорхойлолтод нийцээгүй, байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй, батлагдсан бүтэц орон тооноос 4 орон тоо илүү ажиллуулсан.
- ✓ “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-ын зарим баталсан ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагын дагуу ажилчдын хувийн хэргийг үзэж тулгахад мэргэжил зөрүүтэй 4, мэргэшил зөрүүтэй 3, ажлын туршлага зөрүүтэй 1 нийт давхардсан тоогоор 6 ажилтан ажлын байрны тодорхойлолтын дагуу шаардлага хангахгүй байна. Байгууллагын даргын албан тушаалын тодорхойлолтыг баталж өгөөгүй байна.
- ✓ “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ нь байгууллагын захирлын ажлын байрны тодорхойлолтыг батлаагүй, 15 ажилтан баталсан ажлын байрны тодорхойлолтод нийцэхгүй байна.

Худалдан авах ажиллагааны талаар:

“Алтай Усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ эдийн засгийн зорилтот түвшинг батлуулахдаа хөрөнгө оруулалтын зардлыг тусад нь задалж баталж өгөөгүй 40.6 сая төгрөгийн худалдан авалтыг нийт өртгөөр нь худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гэрээ байгуулсан.

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ нь байгууллагын дарга нь өөрийн хамаарал бүхий этгээд болох төрсөн дүү, 2 хүүтэйгээ ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Үр ашиггүй зардлын талаар:

2.4.2.3. “Ундарга-Алтай” ААТҮГ нь 2019 онд 3.9 сая төгрөгийн, 2020 онд 1.6 сая төгрөгийн, 2021 онд 5.2 сая төгрөгийн 2022 онд 0.96 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Тухайлбал: 2019 онд тэмцээний оролцооны болон бусад зардалд 3.0 сая төгрөг, 2020 онд буудлын төлбөрт 1.6 сая төгрөг, 2021 онд шагналд 4.5 сая төгрөг, 2022 онд орон сууцны байцаагч нарт 0.96 сая төгрөгийн нэгж, шатахууны зардал гаргасан байна. Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол, УИХ-ын 2022 Төрийн хэмнэлтийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 388 дугаар тогтоолуудыг зөрчсөн байна.

2.4.2.4. “Ундарга-Алтай” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин дэд захирлыг томилон ажиллуулж 2021 онд 5.6 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна. Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар орон сууцны байцаагч нарт 2022 оны 1-5 сард 0.9 сая төгрөгийн гар утасны зардал, шатахууны зардал олгосон байна.

2.4.2.5. “Солонго дулааны станц” ААТҮГ нь 2021 онд алдагдалтай ажилласан байхад ажилчдад 2.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг нүүрсээр олгосон.

2.4.3 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний шалгуур үзүүлэлтэд хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага үндэслэлийг сайтар тооцож, батлуулан, үр өгөөжийг сайжруулахаар байна.

2.4.3.1. Аудитад хамрагдсан 12 хуулийн этгээдүүд нийт 44,033.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 308.8 сая төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайландаа бүртгэсэн байна.

2.4.3.2. Аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудтай

жил бүр өмч эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнэдэг бөгөөд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор хөрөнгийг коджуулах, тэмдэг тэмдэглэгээ тавих, хөрөнгөнд тавих дотоод хяналтыг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хийлгэх, зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна.

2.4.3.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөнд биет тооллого хийж хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүртгэлд хяналт хийлээ. Үүнд:

“Ундарга-Алтай” ААТҮГ

- ✓ 7 төрлийн 4.3 сая төгрөгийн хөрөнгө шинээр худалдан авсан, бүртгэлд тусгагдаагүй
- ✓ Гадны байгууллагын 41 төрлийн хөрөнгийг ашиглаж байна. Тухайлбал: Байгууллагын НББ-д бүртгэлтэй байгаа барилга байгууламжийг “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ашиглаж байгаа бөгөөд тус байгууллага нь Мэргэжлийн хяналтын газрын хуучин барилгыг конторын зориулалтаар ИТХ-ын шийдвэргүйгээр ашиглаж байна.
- ✓ Тус байгууллагын гүйцэтгэх захирал нь үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй цэвэр усны нөөцийн 3 худгийг төрийн байгууллагуудад газар тариалангийн чиглэлээр зөвшөөрөлгүй ашиглуулж байна.
- ✓ Бараа материалд үндсэн хөрөнгийн шинж чанартай 17 төрлийн 9.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогыг аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2022 оны 05 дугаар сарын 20-нд хийсэн хөндлөнгийн биет тооллогоор байршил зүйн схем зураг, 2 автомашин, 1 чиргүүл нийт 10.3 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан байна.
- ✓ Мөн цэцэрлэгийн хуучин барилга тус байгууллагын дансанд бүртгэсэн.
- ✓ Байгууллагын 6109м² газрын гэрчилгээний нэрийг солиулаагүй байна. Хөрөнгийг коджуулаагүй, эзэмшигчдэд картлуулж өгөөгүй байна. 2018 оноос хойш хөрөнгө оруулалт огт хийгдээгүй шинэчлээгүй хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэн 2017 онд хүлээн авсан 349.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн уурын зуухны барилгыг одоо болтол ашиглалтгүй байна.
- ✓ Байгууллагад ашиглах боломжгүй, үлдэх өртөггүй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 217.3 сая төгрөгийн өртөг бүхий 24 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

“Говь-Алтай АЗЗА” ТӨХК

- ✓ Хөрөнгийн биет тооллогоор 42.2 сая төгрөгийн үнэ бүхий автобус дутагдсан. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 48 дугаар тогтоолоор “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг данснаас хасаж хүлээлгэн өгөх, автомашиныг засаж сэлбэн Говь-Алтай аймгийн ардын дуу бүжгийн “Алтай” чуулгад эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах шийдвэр гарснаар ардын дуу бүжгийн “Алтай” чуулга нягтлан бодох бүртгэлдээ орлого авч, автомашиныг эзэмшиж байна. Гэвч “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-д давхар бүртгэлтэй, хөрөнгө нь ардын дуу бүжгийн “Алтай” чуулгад байна.
- ✓ Зам тээврийн яамнаас 2021 онд ирүүлсэн 2 Маз автомашин бүртгэлгүй байна.
- ✓ Үндсэн хөрөнгөд үлдэх өртөггүй 47 ширхэг 331.2 сая төгрөгийн хөрөнгө байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ

- ✓ Тооллогоор мөнгө нь 2021 онд шилжсэн боловч хөрөнгө ирээгүй, данс бүртгэлд бодитоор байхгүй хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой 10.0 сая төгрөгийн 50 квт-ын 2ш хөдөлгүүр дутагдсан.
- ✓ Тооллогоор 0.6 сая төгрөгийн нүүрс дутагдсан.

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ

- ✓ Бараа материалын шинжтэй боловч үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6.9 сая төгрөгийн хөрөнгө байна.
- ✓ Нягтлан бодох бүртгэлд үлдэх өртөггүй 633.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.
- ✓ Тооллогоор 17.9 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. Үүнээс 14.3 сая төгрөгийн хашаа, хайс хулгайд алдагдаж цагдаагийн байгууллагад хандсан боловч хөрөнгө олдоогүй. Тус хайс, хашаа үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байна.

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ

- ✓ Үндсэн хөрөнгөд 1,076.8 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг 6 багцад бөөн дүнгээр бүртгэсэн байна.
- ✓ Тооллогоор 5.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө дутагдсан.
- ✓ Үлдэх өртөггүй 14.4 сая төгрөгийн хөрөнгө үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй.

“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ

- ✓ Ханын цэцгийн тавиурыг үнэ тогтоон НББ-д орлого аваагүй, 8.0 сая төгрөгийн камер, дохиолол, дэлгэц, галын хорыг -1 хөрөнгөөр бүртгэсэн байна.
- ✓ Үндсэн хөрөнгөнд бараа материал болох хогийн сав бүртгэсэн.

2.4.3.4. Хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн судалгаа хийж үзэхэд 15 автомашины

хувийн хэрэг хөтлөөгүй, 214.2 сая төгрөгийн 6 автомашин гадны өмчлөгчтэй, 486.9 сая төгрөгийн 22 машин, механизм ашиглалтгүй эвдэрсэн байна. Тухайлбал:

- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ-м 13 төрлийн 745.8 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд 28.0 сая төгрөгийн 3 тээврийн хэрэгсэл үлдэх өртөггүй, ашиглагдахгүй ба 2 тээврийн хэрэгслийн хувийн хэргийг хөтлөөгүй.
- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ бүртгэлд байгаа 16 автомашинаас 4 автомашинд техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөөгүй, 4 тээврийн хэрэгсэл гэрчилгээгүй, 2 тээврийн хэрэгслийн өмчлөгч нь хувь хүний нэр дээр байна. Нийт авто машины 44 хувь буюу 274.1 сая төгрөгийн өртөг бүхий 7 автомашин нь ямар ч ашиглалтгүй, эвдэрсэн байдалтай байна. Мөн Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 11.5 сая төгрөгийн үнэтэй Ухдаг трактор нь “Бигэр шим” ХХК-ийн, 9.6 сая төгрөгийн үнэтэй ХОНДА INSITE 84-58 ГАУ Есөнбулаг сумын ЗДТГ-ын нэр дээр бүртгэлтэй байна.
- ✓ “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн Байгууллагад 7 төрлийн 139.7 сая төгрөгийн машин, механизм эвдэрсэн ашиглалтгүй.
- ✓ “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ-ын Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 тээврийн хэрэгсэл Есөнбулаг сумын ЗДТГ-м өмчлөлтэй, шилжүүлээгүй, Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг хөтлөөгүй, мөн 20.0 сая төгрөгийн авто машин эвдрэлтэй ашиглалтгүй байна.
- ✓ Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 24.9 сая төгрөгийн өртөг бүхий 4 тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөөгүй, ашиглалтгүй байна.

2.4.3.5. Хуулийн этгээдийн газартай холбоотой дараах асуудал байна. Тухайлбал:

- ✓ “Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн Тайшир, Шарга сумын Эвэд байгаа барилгын газрын асуудлыг шийдвэрлээгүй.
- ✓ “Ундарга-Алтай” ААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй 000005298 улсын бүртгэлийн дугаартай 1083 м2 газрыг агуулахын зориулалтаар эзэмшиж байгаа бөгөөд НББ-д бүртгээгүй.
- ✓ “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй стадионы барилгын газар нь өөр байгууллагын нэр дээр өмчлөлтэй байна.
- ✓ Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ -ын нэр дээр бүртгэлтэй 000438418 улсын бүртгэлийн дугаартай 6109 /0.6109/ м2 газрын эзэмшигчийн оноосон нэр өөрчлөгдсөн ч гэрчилгээг солиулаагүй байна.
- ✓ “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ-ын 5023 м2 газар аймгийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр бүртгэлтэй байна.
- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ : Индэрт багийн Харзатын дэрс байршилтай “Аж ахуйн хашаа, нягтаршуулах үйлдвэрийн байгууламж” зориулалттай 1 га газар нь Есөнбулаг сумын Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн А/60 дугаар захирамжаар хүчингүй болсон боловч нягтлан бодох бүртгэлд 180. сая төгрөгийн үнэтэй хашаа гэсэн хөрөнгөөр бүртгэлтэй байна. Мөн хашаанд хатгасан байсан банз байгууллагын хашаанд хураалттай байна.

Хөрөнгө оруулалт, хэрэгцээ шаардлагын талаар:

2.4.3.6. Аймаг, сумын ИТХ-аас харьяа орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын жил бүрийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг батлахдаа тухайн байгууллагад шаардлагатай байгаа хөрөнгийг ямар эх үүсвэрээс бий болгох, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулахтай холбоотой зорилт, арга хэмжээний суурь болон хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийг тодорхой батлах ёстой.

2.4.3.7. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 2019-2021 онуудад нийт 1,598.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд жил бүрийн эдийн засгийн зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг батлуулахдаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тоон дүнгээр баталж байгаа боловч хөрөнгө оруулалтыг дэлгэрэнгүйгээр баталж өгөхгүй байна.

2.4.3.8. “Солонго дулааны станц” ААТҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулалгүй 2019-2021 онд нийт 52.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Солонго хорооллын 1000 айлын орон сууц баригдахаар төлөвлөгдсөний дагуу гадна дулааны болон хэрэглээний халуун усны шугам сүлжээ хийгдсэн. Гэвч энэхүү хэрэглээний халуун усны шугам сүлжээнд гэмтэл гарч байгаа. Мөн Хөгжил хорооллын 7-10 дугаар гудамжны айл өрхийн гадна дулааны шугам сүлжээний хувьд хуучирч муудсан, усны алдагдал гардаг, ихээхэн хэрэглэгчдийн оруулгын шугам сүлжээ нь стандартын бус холболттой зэрэг нь халаалтаар хангахад ихээхэн хүндрэлтэй байдаг тул шугам, сүлжээг солих засварлахад шаардлагатай хөрөнгө оруулалт хэрэгцээтэй байна.

2.4.3.9. “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ нь аймгийн ИТХ-ийн 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 53 дугаар тогтоолоор Есөнбулаг сумын ЗДТГ-ын харьяа хотын нийтийн тээвэр, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн үйл ажиллагааг хариуцан

ажиллуулахаар үүсгэн байгуулсан.

Тус газар нь одоогоор өөрийн оффисын өрөөгүй, компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшилгүй үйл ажиллагаа явуулж байна. Мөн хүлээлгэн өгсөн 3,333.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнөөс 536.0 сая төгрөгийн хөрөнгийн чанар байдал хангалтгүй, цаашид засвар үйлчилгээ хийх шаардлагатай байна.

2.4.3.10. “Ундарга-Алтай” ААТҮГ Тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө байхгүй, эдийн засгийн зорилтот түвшинг батлуулахдаа хөрөнгө оруулалтын зардлыг тусад нь тооцож төлөвлөж өгөөгүй байна. Гүйцэтгэлээр 2019 онд 0.1 сая төгрөг, 2020 онд 2.8 сая төгрөг, 2021 онд 25.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Орон тоо нэмэгдсэнтэй холбоотой тоног төхөөрөмж худалдан авах хэрэгцээ шаардлага үүссэн байна. Мөн гэр хорооллын айл өрхүүдийг эрүүл ахуйн шаардлага хангах усны савтай болгох хэрэгцээ шаардлагын улмаас дээрх хөрөнгө оруулалтууд хийгдсэн байна.

Тухайн байгууллагад бодлогын хэмжээний томоохон хөрөнгө оруулалт хийгдэх шаардлагатай байна. Автомат худгийг ухаалаг системтэй холбосон нь ололттой байна. Гэвч цаашид шугамын усны алдагдлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэхийн тулд “смарт контор” үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын хэмжээнд энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон орон нутгийн өмчит 40 байгууллага байгаагаас 77.5 хувь буюу 31 байгууллага нь уг системд холбогдсон байна. Холбогдоогүй 9 байгууллага байгаагийн 1 нь манай аймгийн “Ундарга-Алтай” ААТҮГ байна.

БҮЛЭГ 3: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй байгаа эсэх

Хөндлөнгийн болон дотоод хяналтыг сайжруулан, үр нөлөөг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

3.1 Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байгаа эсэх

3.1 Төрийн хяналтаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, үр нөлөөгүй байна.

Төрийн хяналтын талаар:

3.1.1. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланд хуулийн дагуу жил бүр аудит хийдэг. 2019-2021 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, болон гүйцэтгэлийн аудитаар нийт 15,390.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,889.0 сая төгрөгийн алдааг залруулж, 9,501.9 сая төгрөгийн зөрчилд шийдвэр өгсөн байна. Үүнээс 5,092.0 сая төгрөгийн зөрчлийг хэрэгжүүлснээр 4,409.9 сая төгрөгийн шийдвэрийн үлдэгдэлтэй ба 3,499.1 сая төгрөгийн зөрчлийг хэрэгжилтийг ирүүлэх хугацаа болоогүй, 910.8 сая төгрөгийн зөрчил хугацаа хэтэрсэн байна. Үүнд:

- ✓ “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ нь хэрэгжээгүй 4.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 5.4 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй. Энэ нь байгууллагын удирдлага солигдсон тул биелэлт ирүүлэх хугацаатай мэдэгдэл хүргүүлэхээр байна.
- ✓ “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ нь хэрэгжээгүй 6.0 сая төгрөгийн төлбөрийн актын, 459.5 сая төгрөгийн зөвлөмжийн үлдэгдэлтэй. Энэ нь “Хөгжлийн банканд орон сууцны төлбөрийн хүүд 459.5 сая төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн” зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад 2021 онд өгсөн зөвлөмж байна.
- ✓ Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь хэрэгжээгүй 9.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 521.6 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэрийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлснээр хариуцлага тооцсон байна.
- ✓ “Нийтлэг үйлчилгээ” УТҮГ нь хэрэгжээгүй 8.4 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэлтэй. .

Дээрх шийдвэрийг холбогдох байгууллага нь арга хэмжээ авч хэрэгжүүлэх шатандаа байна.

Тусгай зөвшөөрөл

3.1.2. “Суурин дулаан” ААТҮГ-ын дулаан түгээх, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах 2 тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байна.

Хуулийн этгээдийн татан буулгах шийдвэрийн хэрэгжилт

3.1.3. “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ, “Барилгын зураг төсвийн товчоо” ОНӨААТҮГ, “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, дуусгалтын балансыг гаргуулан, өр авлагыг нь барагдуулж ажиллах үүрэг бүхий татан буулгах комиссыг байгуулсан.

Гэтэл 2019 оны 6 дугаар сарын 30-наар “Барилгын зураг зүйн товчоо” ОНӨААТҮГ-ын татан буулгах ажиллагаа дуусгавар болсон. Харин “Орон сууцны алба” ОНӨААТҮГ-ын дуусгалтын баланс гараагүйгээс шалтгаалан татан буулгах ажиллагааг хийх боломжгүй өдий хүрсэн байна.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 07 өдрийн 75 дугаар тогтоолоор Есөнбулаг сум, Алтай хотын иргэдийг стандарт шаардлагад нийцсэн ундны усаар хангах зорилготойгоор байгуулагдаж байсан.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор татан буулгах шийдвэрийг гаргаж комисс томилсон байна. Тус комиссын 2022 оны 06 дугаар сарын 02 дугаар тогтоолоор хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх, өглөг, авлагыг барагдуулах асуудлыг шийдвэрлэхээр байна. Мөн Орон нутгийн өмчийн газраас 1,325.0 сая төгрөгийн балансын үнэтэй барилга байгууламж, машин техник хэрэгслийг багцлан дуудах доод үнийг 362.0 сая төгрөгөөр тогтоон дуудлага худалдаа явуулах гэж байна.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20тн, 40тн-ийн багтаамжтай, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөөгүй 2 контейнерыг аймгийн ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны 97 дугаар тогтоолоор акталж устгахаар тогтоол гарч худалдан борлуулсан байна.

Орон нутгийн өмчийн газрын өмч хувьчлалын орлогын дансанд 2022 оны 01 дүгээр сард тус 2 контейнерыг үлдэх өртгөөр нь буюу 3.3 сая төгрөгөөр худалдан борлуулсны төлбөр байна.

Одоогийн зах зээлийн ханшаар 20 тн-ын контейнер 7.0-8.0 сая төгрөг, 40 тн-ын контейнер 12.0-13.0 сая төгрөгийн үнэтэй байгаа тул төсөвт хохирол учруулсан байж болзошгүй гэж үзэж хууль хяналтын байгууллагад шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжлахаар шийдвэрлэсэн.

3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй эсэх

3.2 Дотоод хяналтыг сайжруулж, хөндлөнгийн хяналтаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцох нь зүйтэй байна.

3.2.1. Эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудад өмчлөгчдийн зүгээс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хянадаг компанийн дотоод хяналтын хэлбэр нь дотоод аудит байдаг. Төрийн өмчийн компаниудын хувьд гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр ашиг, санхүүгийн болон бүх төрлийн тайлагналын үнэн зөв байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянахад дотоод аудит чухал үүрэгтэй.

Дотоод аудитын албаны үүргийг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаагаар хязгаарлаж болохгүй бөгөөд компанийн үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой бүх талын хяналт, үр ашгийг үнэлж сайжруулахад түүний үүрэг чиглэгдэх ёстой. Дотоод аудитор нь зөвхөн санхүүгийн сайн шинжээчид байхаас гадна компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлээр мэргэшсэн ажилтнууд байна.

Компани дотоод аудитын албаны журамтай байхаас гадна дотоод аудитад мөрдөх үйл ажиллагааны болон ёс зүйн стандартууд болон дотоод аудитын төлөвлөлт, арга зүй, тайлан зөвлөмжийн загвар, зөвлөмжийн хэрэгжилтийн мониторинг хийх аргачлал, ажлын баримтын загваруудыг багтаасан удирдамжийн баримт бичигтэй байх ёстой.

3.2.2. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-д заасны дагуу орон нутгийн өмчит ААТҮГ-ын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг явуулна.

Аудитад хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд дотоод хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

"Говь-Алтай АЗЗА" ТӨХК:

- ✓ 2019 онд Зам, тээврийн яамны /2019.07.10-ны өдрийн 38-07-067-004/65/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар Алтай-Баянхонгор, Алтай-Ховд, Алтай-Улиастай, Алтай-Бургастай чиглэлийн авто замуудад технологийн эвдрэл болон арчлалтын ажлуудыг хийснээр зорчигчдын аюулгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.
- ✓ Мэргэжлийн хяналтын газрын /2019.03.15-ны 08-07-024/01/19/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар Улсын чанартай зам, замын байгууламжид 108 ширхэг тэмдэг шинээр суурилуулснаар замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдсан.
- ✓ Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн зөвлөмж /2019.04.01-ны 06/020/01/ зөвлөмж өгөгдсөнөөр Ахмадын санг байгуулснаар ахмадуудад дэмжлэг тусалцаа үзүүлж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн. Улирлын чанартай ажиллагсдын НДШ-г төлснөөр ажилчдын нийгмийн баталгаа хангагдсан.
- ✓ 2020 онд Мэргэжлийн хяналтын газрын 2020.04.27-ны 03/267/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар Алтай-Баянхонгор чиглэлийн авто замын нүхэн эвдрэлийн ажлыг хийж тээврийн хөдөлгөөнийг осол авааргүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.
- ✓ Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын /2020.07.27-ны 01-07-035/249/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар Алтай-Баянхонгор, Алтай-Ховд чиглэлийн замын эвдрэлийг арилгаж хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан.
- ✓ Мэргэжлийн хяналтын газрын /2020.11.18-ны 01-07-008/66/ зөвлөмж өгөгдсөнөөр ажилчдыг коронавируст халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлсэн.
- ✓ 2021 онд Зам, тээврийн яамны /2021.06.01-ны 38-07067-004/08/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар Алтай-Баянхонгор, Алтай-Ховд чиглэлийн авто замын нүхэн эвдрэлийг арилгаж, тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн хийснээр зорчигч, тээврийн хэрэгслийг аюулгүй тав тухтай зорчих нөхцөлөөр хангасан.
- ✓ Мэргэжлийн хяналтын газрын /2021.10.07-ны 01-07-055/96/ албан шаардлагыг биелүүлэн ажилласнаар улсын чанартай зам, замын байгууламжийн засвар арчлалтыг сайжруулж зорчигч, тээврийн хэрэгслийг аюулгүй тав тухтай зорчих нөхцөлөөр хангасан.
- ✓ Мөн дотоод хяналтын ажилтан ажиллуулж 2019 онд 10, 2020 онд 9, 2021 онд 8 шалгалтыг төлөвлөн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

"Ундарга-Алтай" ААТҮГ: Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулсан боловч хэрэгжилтийг хангуулаагүй, үр нөлөөг тооцоогүй, дотоод хяналт хангалтгүй байна.

"Говь-Алтай аймгийн Инноваци бизнес хөгжлийн төв" УТҮГ: Дотоод аудитын нэгж, хөндлөнгийн хяналт хийгдээгүй байна.

"Суурин дулаан" ААТҮГ нь Дотоод хяналтын ажилтан томилогдсон боловч 2020-2021 онд төлөвлөсөн болон гүйцэтгэж тайлагнасан ажил байхгүй байна. Жаргалан сумын "Суурин дулаан" ААТҮГ-ын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтыг Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албанаас 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №3 дугаартай шалгалтаар 74.6 сая төгрөгийн дүн бүхий гурван заалттай нэг албан шаардлага хүргүүлж, 0.2 сая төгрөгийг тухай байгууллагын дансанд төвлөрүүлэхээр акт тогтоож, үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлэх арга хэмжээний найман зөвлөмж хүргүүлсэн байна. Уг хяналтын хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхээр улсын байцаагчийн гаргасан захиргааны акт, шийдвэрийг ирүүлэхээр тусгасан байна.

"Алтай хотын тохижилт үйлчилгээ" ААТҮГ нь дотоод хяналт хариуцсан ажилтан томилж байгууллагын хэмжээнд төлөвлөгөө гарган ажилласан гэх боловч баримтаар нотлогдохгүй, хяналт шалгалтын баримт материал ирүүлээгүй, үр дүнгүй байна. Дотоод аудитын нэгжээс хяналт шалгалт хийгдээгүй, хөндлөнгийн байгууллагаас Төрийн аудитын байгууллагаар жил бүр санхүүгийн тайлангийн аудит, 2019 онд гүйцэтгэлийн аудит хийгдсэн байна.

"Солонго дулааны станц" ААТҮГ:

- ✓ 2020 оны 02 дугаар сарын 07-ны 06 дугаар тушаалаар дотоод хяналтын үйл ажиллагаа явуулах нэгжийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Гэвч дотоод хяналтын нэгж үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт хийгээгүй байна.
- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 онд байгууллагын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хөтлөлтөд тус тус хяналт

шалгалт хийжээ. Санхүүгийн хяналт аудитын албанаас хийгдсэн хяналт шалгалтаар 14.5 сая төгрөгийн зөрчил илэрч хэрэгжилт тооцсон байна. Шилэн данстай холбоотой 8 заалт албан шаардлага өгч биелэлтийг тооцсон байна.

- ✓ Аудитын хамрах хугацаанд Мэргэжлийн хяналтын газраас “Солонго дулааны станц” ААТҮГ-ын халаалтын зуухны үйл ажиллагаанд хяналт хийж дүгнэлт гаргасан байна.
- ✓ “Солонго дулааны станц” ААТҮГ-ын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах 9 заалт бүхий албан шаардлага өгсөн байна. Хэрэгжилтийг 35 хувьтай байна гэж үнэлсэн байна.
- ✓ Мэргэжлийн хяналтын газраас 2020 онд “Солонго дулааны станц” ААТҮГ-ын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт хийж дүгнэлт гаргасан байна. Хяналтаар цаашид авах арга хэмжээний талаар 57 заалт бүхий санал хүргүүлжээ. Биелэлтийг тооцож хүргүүлсэн гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.
- ✓ Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны 03 сард иргэнээс гарсан гомдлын дагуу хяналт шалгалт хийж улсын байцаагчийн 4 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 75%-тай хангуулсан байна.
- ✓ Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийсэн байна. Хяналтаар 15 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн бөгөөд биелэлтийг тооцсон байдал нь баримтаар нотлогдохгүй байна.
- ✓ Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж ажилчдын цалин хөлстэй холбоотой 2 заалт бүхий албан шаардлага хүргүүлснийг хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллажээ.

“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ: Дотоод хяналтын нэгж байгуулаагүй, газрын үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт хийгээгүй байна.

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ, Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ, “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ, “Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ нь дотоод хяналтын нэгжийг томилоогүй, хяналт хийгдээгүй байна.

3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байгаа эсэх

3.3 Хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны талаар олон нийт мэдээлэлгүй байна.

3.3.1. Компанийн жилийн тайлан нь тухайн компанийн жилийн үйл ажиллагааны үр дүнг харуулах чухал баримт бичиг тул түүнд байх ёстой мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв тусгаж хугацаанд нь гаргаж нийтэд хүргэх явдал маш чухал ач холбогдолтой. Иймд тайланд тусгах ёстой мэдээллийн жагсаалт, хариуцан гаргах этгээдийг тодорхой заасан мэдээллийн журамтай байвал зохино.

3.3.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7.7-т “Нийтийн мэдээллийг ашиглахад хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний мэдээлэл авах эрх, эрх чөлөөг үл хязгаарлах, төрийн байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй байх, хүн, хуулийн этгээд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл боломжийг бүрдүүлнэ” заасан.


“Ундарга-Алтай” ААТҮГ нь www.undarga-altai.water-mogolia.com албан ёсны веб хаягтай бөгөөд 2021 онд мэдээллийг шинэчлээгүй байна. Уг сайтад цаг үеийн мэдээ мэдээллийг тавьсан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаа төсөв хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлээгүй байна. Харин шилэн дансны цахим системд мэдээлсэн байна.

“Ундарга-Алтай” ААТҮГ, “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-аас бусад төрийн болон орон өмчит хуулийн этгээдүүд нь үйл ажиллагааны тайлан мэдээлэх албан ёсны вэб сайт хаяггүй байна.

3.3.3. Компанийн тухай хуулийн 91.3⁸-т заасны дагуу компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй. Компани өөрийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж нээлттэй болгох нь компани дээр хийгдэх сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийг мэдэх, улмаар түүнийг ёс журмын дагуу хийх, нийтэд нээлттэй болгох зэрэгт чухал ач холбогдолтой.

⁸ Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

Улмаар Компанийн тухай хуулийн 97.1⁹, 97.1.12¹⁰-т заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг баримт бичигт хадгалахаар байна. Аудитад хамрагдаж байгаа хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргаж архивын баримт бичигт хадгалаагүй байна.



Дээрх дүгнэлтэд үндэслээд дараах шийдвэрийг гаргаж байна.

“Говь-Алтай АЗЗА” ТӨХК

Зөвлөмж

“Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн Захирал Ш.Тогтмолд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг эрх бүхий этгээдээс тогтоосон нөхцөлд олгох
2. Тайшир сумын болон Шаргын Ээвд байгаа барилгын газрын асуудлыг шийдвэрлэх
3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах

Албан шаардлага

“Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн Захирал Ш.Тогтмолд:

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Ажлын байрны тодорхойлолтод нийцэж ажилтантай гэрээ байгуулах, хувийн хэргийн бүрдлийг хангах
3. Ардын дуу бүжгийн “Алтай чуулга”-д давхар бүртгэлтэй байгаа автобусыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандаж, хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх
4. Зам тээвэр, хөгжлийн яамнаас 2021 онд үнэ төлбөргүй ирсэн 2 автомашиныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлд бүртгэх
5. Үлдэх өртөггүй хөрөнгө, ашиглалтгүй, эвдэрсэн хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

Ундарга-Алтай” ААТҮГ:

Зөвлөмж

Орон нутгийн өмчийн газарт

1. “Ундарга-Алтай” Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм, бүтэц орон тоог уялдуулан батлуулах

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, Захирал Б.Энхболд

1. Урт хугацаат зээлийн асуудлыг шийдвэрлэх
2. Цэвэр усны нөөцийн 3 худгийн асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх

Захирал Б.Энхболд

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах

Захирал Б.Энхболд, нягтлан бодогч Г.Должинжав

1. Бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй тооцон боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
2. Хуульд нийцүүлэн дэд захирлын орон тоог хасаж, хэмнэлт гарган ажиллах
3. Үр ашиггүй зардлыг хэмнэн, төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах
4. Барилга байгууламжтай холбоотой асуудлуудыг холбогдох газарт хандан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах
5. Өөрийн эзэмшилд байгаа газрыг НББ-д бүртгэх ажлыг зохион байгуулах

⁹ Компани нь дараах баримт бичгийг хадгалах үүрэгтэй:

¹⁰ компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт;;

6. Үлдэх өртөггүй хөрөнгийн асуудлыг холбогдох газарт хандан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах
7. Тооллогоор илүүдсэн хөрөнгийг асуудлыг холбогдох газарт хандан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах
8. Тээврийн хэрэгслийн хувийг журмын дагуу хөтөлж хэвших
9. Үндсэн хөрөнгийг бараа материалын тайланд тусгасан зөрчлийг арилгах
10. Дээрх зөрчилтэй орон сууцны айл өрхүүдийн усны хэрэглээ, төлбөрийн ногдуулалтад хяналт тавьж ажиллах
11. Дээрх 14 ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт хийн, тоолууржуулан усны төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллах

Захирал Б.Энхболд, эдийн засагч Ж.Угтахбаярт

1. Дотоод хяналт шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулж, үр дүнг тооцдог байх

Захирал Б.Энхболд, Хүний нөөцийн менежер Н.Бурмаа

1. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах

Батлагдсан ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагыг хангасан ажилтныг авч ажиллуулах

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын Захирал Д.Наранчимэгт:

1. Эзэмших эрхтэй 9136.2 м2 газрыг үнэлэн нягтлан бодох бүртгэлд бүртгэх

Албан шаардлага

“Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын Захирал Д.Наранчимэгт:

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Хөгжлийн банканд төлөх орон сууцны зээлийн төлбөр төлөх хуваарийг түрээслэгчтэй хийсэн гэрээний төлөлтийн хуваарьтай уялдуулан эдийн засгийн хүндрэл учруулахгүйгээр шийдвэрлэх
3. Хууль эрх зүйн хүрээнд гарсан холбогдох шийдвэрийг үндэслэн гэрээний хэрэгжилтийг хангуулах
4. Дотоод хяналтын ажилтан томилон, шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулж, үр дүнг тооцдог байх

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт:

1. Хөгжлийн банканд төлөх орон сууцны зээлийн хүүг төлөх хөрөнгийн эх үүсвэрийг хууль эрх зүйд нийцүүлэх шийдвэрлэх

Суурин дулаан” ААТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх
2. Үйлдвэрийн захирлын ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг батлаж, мөрдүүлэх

Албан шаардлага

Суурин дулаан” ААТҮГ захирал Р.Мягмардоржид:

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах
3. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах
4. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө баталж, хяналт шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулж, үр дүнг тооцдог байх
5. Эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй тооцон боловсруулан, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
6. Хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэр, бусад баримт бичгийн бүрдлийг хангах

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ

Албан шаардлага

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Х.Баатарзоригт

1. Төрөөс нэхэмжилсэн нэхэмжлэлийн дагуу орлогоо бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах

Есөнбулаг сумын Засаг дарга А.Алтанхуягт

1. Төсвийн тухай хуулийн дагуу цаашид сумын орон нутгийн орлогод орох төлбөр хураамжийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлэх.

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын Захирал Ц.Бат-Оршиход:

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Батлагдсан ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагыг хангасан ажилтныг авч ажиллуулах
3. Хөрөнгөтэй холбоотой асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх
4. Хогны төлбөр хураамжийг тухай бүр хурааж, ногдуулалтыг үйл ажиллагаатай уялдуулан бодитой тооцох
5. Хогны төлбөр хураамжийг хураан авсан тухай бүр орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх
6. Ногдуулалтыг үнэн зөв хийж, тооцоо нийлж барагдуулах ажил зохион байгуулах
7. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө баталж, шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулан, үр дүнг тооцдог байх
8. Хөгжлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллах
9. Хөрөнгө, бараа материалыг стандартын дагуу бүртгэлд тусгаж, хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх
10. Хүчингүй болсон газрыг нягтлан бодох бүртгэлээс хасах ажлыг, мөн хашааны банзны асуудлыг шийдвэрлүүлж төсвийг үрэлгэн зарцуулахгүй байх.
11. Өмнөх онд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжилтийг хангуулж, биелэлт ирүүлэх

Төлбөрийн акт

“Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ-ын Захирал Ц.Бат-Оршиход:

1. Дутуу төвлөрүүлсэн хогны төлбөрийн 0.4 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх
2. Аж ахуй нэгж, албан байгууллагын хогны төлбөрийн дутуу 2.1 сая төгрөгийг төлүүлж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх

“Солонго дулааны станц” ААТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар

1. Байгуулсан гэрээг жил бүр дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн ИТХ-ын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж ажиллах
2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх
3. Захирлын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах

Албан шаардлага

“Солонго дулааны станц” ААТҮГ -ын Захирал А.Дэлгэржаргалд

1. Бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй тооцон боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
2. Эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
3. Дотоод хяналт шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулж, үр дүнг тооцдог байх
4. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах
5. Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих сангаас авсан зээлийг тооцоо нийлж баталгаажуулан, гэрээний заалтыг мөрдөж ажиллах
6. Зардлыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, дотоод хяналт, санхүүгийн хариуцлагыг сайжруулах

Төлбөрийн акт

Захирал А.Дэлгэржаргал, Нягтлан бодогч Б.Хаш-Эрдэнэ

1. Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих сангаас авсан зээлийн гэрээт хугацаанд төлөгдөөгүй 40.3 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүүг төлж барагдуулах
2. Тооллогоор дутагдсан 10.6 сая төгрөгийн хөрөнгийг төлүүлэх

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх
2. Захирлын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдсан уурын зуухны ашиглалтад хяналт тавьж үр өгөөжийг бий болгох

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын дарга М.Батзаяад

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Дотоод хяналт шалгалтыг үр нөлөөтэй зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах
3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэл тооцоололтой баталж, батлагдсан зорилтод түвшинг хэрэгжүүлж ажиллах
4. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг мөрдүүлж, чадавхжуулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулах
5. Цаашид ашиглалтгүй болсон хөрөнгийг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх
6. Газрын гэрчилгээ эзэмшигчийн бүртгэлийн нэрийг өөрчилж, солиулах арга хэмжээ авч ажиллах
7. Дарив сумын Цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлд давхар бүртгэлтэй конторын барилгын асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх.

Төлбөрийн акт

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын дарга М.Батзаяад

1. Хөрөнгийг тооллогоор дутагдсан 10.3 сая төгрөгийн хөрөнгийн буцаан төлүүлэх

Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх

Албан шаардлага

Эрдэнэ сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын захирал Э.Мягмаржав, нягтлан бодогч Б.Нарантуяа

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллан, үр дүнг тооцдог байх
3. Үлдэх өртөггүй хөрөнгийн асуудлыг холбогдох газарт хандан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах

“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” УТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх
2. Захирлын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах

Албан шаардлага

Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуягт

1. “Цоохор алт” ХХК-ийн түрээсийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, илүү талбай ашиглаж байгаад түрээсийн төлбөрийг төлүүлэх арга хэмжээ авах

Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын захирал М.Мягмарбаярт:

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах
3. Ажлын байрны тодорхойлолтод нийцсэн иргэнтэй гэрээ байгуулах
4. Эрх бүхий байгууллагын батлагдсан бүтэц орон тоонд багтаан ажиллах
5. Цэцгийн тавиурыг нягтлан бодох бүртгэлд орлого авч орлого, нийт дүнгээр бүртгэсэн болон бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн зөрчлийг арилгах

6. Босго үнээс давсан төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах
7. Нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн боловч аймгийн ЗДТГ-ын эзэмшилд байгаа газрын зөрчлийг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлүүлэх
8. Байгууллагын богино хугацааны болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж ажиллах

“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Захирлын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах

Албан шаардлага

“Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-ын захирал Т.Эрхэмбаярт

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Дотоод хяналтыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллах
3. Байгууллагын богино хугацааны болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулж ажиллах
4. Ажлын байрны тодорхойлолтод нийцсэн иргэнтэй гэрээ байгуулах

“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх

Албан шаардлага

“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ-ын дарга И.Гантулгад

1. Эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй тооцон боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах
3. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллан, үр дүнг тооцдог байх

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ

Зөвлөмж

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх

Есөнбулаг сумын Засаг дарга А.Алтанхуягт

1. Захирлын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах.

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт:

1. Байгууллагын даргын өөрийн хамаарал бүхий этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан асуудалд дотоод хяналтыг хэрэгжүүлэх

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ-ын дарга Ж.Дашдаваад

1. Эрх бүхий албан тушаалтын нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж баримтад хадгалах
2. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж ажиллан, үр дүнг тооцдог байх
3. Авто тээврийн хэрэгслийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж, гэрчилгээг нэр дээр шилжүүлэн авч, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийг хөтлөх
4. Үндсэн хөрөнгөд бөөн дүнгээр бүртгэсэн бүртгэлийн зөрчлийг арилгах
5. Үлдэх өртөггүй хөрөнгийн асуудлыг холбогдох газарт хандан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах
6. Ажлын байрны тодорхойлолтод нийцсэн ажилтныг авч ажиллуулах

Төлбөрийн акт

“Алтай хотын цогц үйлчилгээний газар” УТҮГ-ын дарга Ж.Дашдаваад

1. Тооллогоор дутагдсан 5.6 сая төгрөгийн хөрөнгийг төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох

"Гэгээн нуур цэвэр ус" ААТҮГ, "Орон сууцны алба" ОНӨААТҮГ

Албан шаардлага

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатарт

1. "Гэгээн нуур цэвэр ус" ААТҮГ, "Орон сууцны алба" ОНӨААТҮГ-ын татан буулгаж дуусгалтын баланс гаргуулах.

Уламжлах

ҮАГ-ын аудитын гуравдугаар газарт уламжлан нэгдсэн тайланд тусгаж харьяалах байгууллагад зөвлөмж өгөх:

1. Зам тээвэр, хөгжлийн яамнаас аймгуудын "АЗЗА" ТӨХК-нд 2021 онд нэгдсэн журмаар "Маз" автомашины олгосон боловч хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл, үнийн дүн байхгүйн улмаас нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй асуудлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд уламжилж шийдвэрлэж өгөх
2. Күвейтийн сангаас 2008 онд 21 аймгийн "АЗЗА" ТӨХК-уудад тоног төхөөрөмж нийлүүлсэнтэй холбоотой "Говь-Алтай АЗЗА" ТӨХК-нд үүссэн 283.6 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх
3. Дарив сумын "Эрчим хүч" ААТҮГ нь 2018-2021 онд нийт 83.0 сая төгрөгийг зээлийн гэрээ байхгүй, байгууллагын дансаар дамжуулаагүй, анхан шатны баримтгүйгээр хувь хүний данс руу шилжүүлсэн асуудлыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар Монгол Улсын ерөнхий аудиторт уламжлах.
4. "Гэгээн нуур цэвэр ус" ААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөөгүй 20 тн, 40 тн-ийн 2 контейнерыг акталж данснаас хасаж, зах зээлийн ханшнаас доогуур үнээр худалдан борлуулж төсөвт хохирол учруулсан асуудлыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар Монгол Улсын Ерөнхий аудиторт уламжлах

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал:



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠠ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093
Утас: 7048-4004, Факс: 7048-3360


2022.07.08 № 4902

танай _____-ны № _____-т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, шийдвэртэй танилцлаа.

Шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулан ажиллах болно.



ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

0205000863